

У.Туяа, О.Пүрэв, Г.Шүрэнцэцэг
Х.Баярмаа, З.Алтанцэцэг, Г.Түвшинжаргал

ХҮН БА НИЙГЭМ

IV

Ерөнхий боловсролын сургуулийн
4 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
X-822

Хүн ба нийгэм IV: Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн сурах бичиг.
/Туяа У., ба бус; Ред Пунцагсүрэн Д, Оюунтунгалаг О. -УБ.2014. -56х

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөршөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

Формат 84x108/16
Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м²
Хэвлэлийн хуудас 6 х.х

Хэвлэлийн эх бэлтгэлийг “Экимто” ХХК-д бэлтгэж,
“Бест Колор Интернэшнл” ХХК-д 7950 хувь хэвлэв..

ISBN 978-99973-69-39-0

СУРАГЧ ТАНАА

Сурагч та 4-р ангидаа “Хүн ба нийгэм” хичээлийн сурах бичгийг шинээр судлах юм. Сурах бичгээ судалснаар та өөрөөсөө эхлээд гэр бүл, сургууль болон нутгийнхаа амьдрал, нийгмийн үйл явцыг таних, ойлгох, эдгээрийн учир шалтгаан, холбоо хамаарал, өөрчлөлтийг тайлбарлах, үнэлэх чадвартай болно. Үүний зэрэгцээ нийгмийн холбогдолтой үйл явцад оролцох, хувь нэмрээ оруулах, бусадтай зөв харилцах, хамтран ажиллах зэрэг чадвараа хөгжүүлнэ. Тухайлбал:



- Гэр бүлийн гишүүн гэдгээ ойлгох, үүргээ биелүүлэх;
- Гэр бүлийн гишүүд бие, биенээ хайрлах, дэмжих, хамтран амьдрах, хөдөлмөрлөхөд өөрийн хувь нэмэр оруулах;
- Сургуулийн хамт олны зохион байгуулалт, хамт олны гишүүний үүрэг, оролцооны талаар хэлэлцэх;



- Өөрийн нутгийн байрлалыг газрын зурагт заах, тэмдэглэх;
- Нутгийн хүмүүсийн амьдрал, хөдөлмөрийг ойлгох, танилцах;
- Нутгийн аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудтай танилцах, судлах;
- Мэдээллийн талаар ойлгох, мэдээллийн эх сурвалжийг ялгах, ашиглах;



- Хувь хүний онцлог, ялгаа, үүргийн талаар тайлбарлах, өөрийн үнэлэлт өгөх;
- Хамтын амьдрал, харилцаа, нийгэм гэсэн үг хэллэгтэй танилцах, хэрэглэх;
- Сургууль, хамт олны дүрэм, журмыг мөрдөх, сахих, дүрэм зохиох;



- Өөрийн үүргээ мэдэх, биелүүлэх, хариуцлагатай байж сурах;
- Хувь хүн нийгэм, соёлын ялгаатай орчны тухай тайлбарлах;
- Өөрийн болон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, хангах эрмэлзэлтэй болох;

Та сурах бичгээ судлахдаа дараах таних тэмдгүүдийг ашиглаарай.



Бидний ярилцах зүйл



Тохиолдол, баримтыг шинжлээрэй



Уншаад ярилцаарай




Хамтдаа хийж бүтээгээрэй



Санамж

I. БҮЛЭГ: СУРАГЧ БА ГЭР БҮЛ, СУРГУУЛИЙН АМЬДРАЛ

СЭДЭВ 1. БИ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН



Бидний гэр
бүл бол бичил
нийгэм юм.



Бидний ярилцах зүйл:

- Гэр бүлийн гишүүн гэж хэн бэ?
- Гэр бүлийн гишүүд ямар үүрэгтэй вэ?

Түлхүүр үг: Гэр бүл, гэр бүлийн гишүүн, ургийн бичиг



*Сайн байцаана уу, найзуудаа.
Би та бүхэнд гэр бүлийнхнийхээ
тухай танилцуулъя. Тэгээд бүгдээрээ
гэр бүлийн гишүүн гэж хэнийг хэлдэг
тухай ярилцацгаая.*



Шинжлээрэй

Намайг Зоригтын Азбаяр гэдэг. Би 2004 онд Улаанбаатар хотын Эх нялхсын нэгдсэн эмнэлэгт, айлын хоёр дахь хүү болж төрсөн. Би эмээ, аав, ээж, ах, дүүгийн хамт сургуулаа амьдардаг. Аав, ээж хоёр маань ажил хийдэг. Ах бид хоёр сургуульд сурдаг. Харин дүү цэцэрлэгт явдаг. Эмээ маань тэтгэвэрт гарсан. Би гэрийнхэндээ өөрийн чадах бүх зүйлээрээ тусалж, дүүгээ цэцэрлэгээс нь авдаг, мөн гэрээ цэвэрлэдэг. Чөлөөт цагаараа морин хуурын дугуйланд суралцдаг. Манай гэр бүлийнхэн тус тусдаа өөр өөрийн гэсэн ажил, үүрэгтэй.

Бид өөр өөрийн ажил, сургуультай ч бие биедээ тусалж, цаг гаргаж, хамтаараа байх, хөдөлмөрлөх дуртай. Ялангуяа, аав, ээжийн цалин буусан үед манайхан заавал гэр бүлээрээ кино үзэх юм уу, хотоос гарч цэвэр агаар, байгальд зугаалдаг. Энэ нь сард нэг удаа болно.

Ах, дүү, бид гурав аавын ярьж, тайлбарлаж өгдөг гэр бүлийн ургийн бичгийн тухай дахин

дахин сонсох дуртай. Аав маань “гэр бүлийн амьдралыг ургийн бичгээс мэдэж болдог” гэж хэлдэг. Надад ч гэсэн манай гэр бүлийн ургийн бичиг нь намайг гэр бүлийн гишүүн гэдгийг баталж, мэдрүүлж байгаагаараа сонирхолтой, бахархууштай санагддаг. Эмээ маань “Хүүхдүүд минь багаасаа удам судраа мэдэж, ургийн бичгээ хөтөлж сур” гэж захидаг.

Асуулт:

1. Азбаярын гэр бүлийн амьдралын тухай юу мэдэж авав?
2. Азбаяр болон тэдний аав, эмээ нь гэр бүлийн ургийн бичгийн талаар ямар бодолтой байна вэ? Харин чиний бодол, санал юу вэ?
3. Танай гэр бүл болон Азбаярын гэр бүлийн ялгаатай ба ижил тал юу вэ?



Өөрийн гурван үеийн ургийн бичгийг зурж тэмдэглээрэй. Ургийн бичгийн зураглал хийхдээ Азбаярын гэр бүлийн ургийн бичгийн зураглалыг ашиглаж болно.


Миний 3 үеийн бичиглэл (загвар)

Өвөг эцэг..... Эмэг эх

Эцэг Эх

Би

Ургийн бичгийн зураглал (4 үеийн)



Тайлбар: Ургийн бичигт өөрийн эцгийн эцгийг өвөг эцэг, эхийн эхийг эмэг эх хэмээнэ.



Инжлээрэй

Миний аав, ээж хоёр гадаад улсад олон хоног ажиллахаар явсан. Би өвөг эцэг, эмэг эхтэйгээ хамт амьдардаг. Тэд тэтгэвэрт гарсан тул албан ажил хийдэггүй. Бидэнд авга ах, нагац эгч нар маань тусалдаг. Аавын дүү буюу авга ах маань эмэг эх, өвөг эцэг бид гуравт түлээ нүүрс, мах, цайны сүү авчирч өгдөг. Харин ээжийн маань эгч, дүү нар буюу миний нагац эгч нар амралтын өдрүүдэд манай гэрийн ажилд тусалдаг. Хоол сайхан хийдэг бага нагац



эгч дэлгүүрээс хүнсний зүйл авч, бидэнд амттай сайхан хоол хийж өгдөг. Цэвэрч нямбай, оёдол, үйлэнд уран дунд нагац маань гэр орныг цэвэрлэж, цэмцийлгэнэ, заримдаа хувцас ч хийж өгнө. Авга, нагац нар минь гэр бүлтэй, зав зайгүй ажилтай ч ийнхүү бидэнд чин сэтгэлээсээ хандаж, тусалж, дэмжиж байдаг нь манай гэр бүлийн сайхан уламжлал, бахархал билээ.

Асуулт:

1. “Би”-ийн гэр бүлийн ургийн бичгийг зураглана уу.
2. "Төрлийн хэлхээ нагац, Төрийн хэлхээ эрдэм" гэдэг үгийн утгыг тайлбарлана уу.
3. Өөрийн авга, нагац нарын талаар бие биедээ танилцуулаарай.
4. Бүгдээрээ гэр бүлийнхээ амьдралын сайн зүйлээс ярилцаарай.



Өөрийн гэр бүлдээ үүрэг, хариуцлага хүлээж, хувь нэмрээ оруулдаг хүнийг гэр бүлийн гишүүн гэдэг. Гэр бүлийн гишүүд харилцан туслалцаж, бие биенээ хайрлах, хүндэтгэх үүрэгтэй. Гишүүн бүр гэр бүлийнхээ аз жаргал, амгалан тайван амьдралыг бий болгоход өөрийн хувь нэмрээ оруулж, чадал, боломжоороо тусалдаг. Гэр бүлийн гишүүн бүр өөрийн хүлээсэн үүргийг гүйцэтгэж, бие биеэ сонсож, асуудлаа хамтран шийддэг. Хүүхэд ч гэсэн гэр бүлийн гишүүн тул үүрэг, хариуцлага хүлээж, өөрийн хувь нэмрээ оруулна.

Гэр бүлийнхнийг нэгтгэж байдаг зүйл бол тэдний хайр, хүндэтгэл, итгэл юм. Гэр бүлээ зохион байгуулах, өөрийн орлого, зарлагаа тооцох, нэмэгдүүлэх, ёс заншлаа хүндэтгэж, өвлөх зэрэг нь гэр бүлийн гишүүн бүрийн эрхэмлэх зүйл юм.

Асуулт:

1. Гэр бүлийн гишүүдээсээ бид юу сурдаг вэ?
2. Гэр бүлийн гишүүн гэж хэн бэ? Тайлбарлана уу.
3. Танай гэр бүлийн гишүүдийн бахархал юу вэ?
4. Тэр бахархлыг хэн бүтээсэн бэ?



Гэрийн даалгавар

- а. Шатрын морины нүүдлээр нүүж, үүсэх үгийг өнгөөр ялгаж будаарай.
- б. Үүссэн үгнүүдийг өгүүлбэр болгон бичээд тайлбарлаарай.

г	а	ү	о
л	и	у	т
ю	э	и	б
д	н	м	ж
з	ф	р	й

х	а	г	р
м	и	ө	т
г	в	ө	б
д	л	м	д
з	ф	е	ь

СЭДЭВ 2. ГЭР БҮЛ ДЭХ МИНИЙ ОРОЛЦОО



Гэр бүлийн гишүүн бүр үүрэгтэй.



Бидний ярилцах зүйл:

- Гэр бүлийн гишүүд юу хийдэг вэ?
- Гэр бүлдээ миний оруулах хувь нэмэр

Түлхүүр үг: Гэр бүл, оролцоо



Хүснэгтийн дутууг нөхөж бичээд, хэлэлцээрэй.

1. Танай гэр бүлийн гишүүд гэртээ юу, юу хийдэг вэ?
2. Чи гэр бүлдээ ямар хувь нэмэр оруулдаг вэ?

Гэр бүлийнхний ажил, оролцоо	Гэр бүлийн гишүүн
Хоолоо бэлтгэх, хийх	Ээж, эгч. Би болон тусалдаг
-	-
-	-
Малаа хариулах	Аав, ах



Инжлээрэй

Манай гэрт өдөр бүр нэг шинэ зүйл болж байдаг. Нэг удаа манайхан нэг өрөөндөө засвар хийхээр боллоо. Бид засварын багийн ахлагчаар аавыг сонгов. Аавын даалгавраар ээж, эгч хоёр хананы цаас, цонхны хөшиг авахаар дэлгүүр лүү явав. Ах бид хоёрд хананы хуучин цаасаа хуулах, цэвэрлэх ажил оногдов. Аав, эмэг эх, дүү хоёрыг зусланд хүргэж өгөөд, хананы цаас наах цавуу авчирч, найруулж бэлтгэсэн.

Хананы цаасыг аав, ах хоёр нааж, эгч, ээж хоёр хоол бэлтгэв. Харин би тэдний



аль алинд нь тусалж байлаа. Ингээд гэр бүлээрээ завгүй ажилласаар орой хананы цаасаа нааж дуусгасан. Манай өрөө гоё, саруулхан, цэвэрхэн болсон байлаа. Бид ээж, эгч хоёрын хийсэн амттай хоолыг идэж, бүгд хийсэн ажилдаа сэтгэл хангалуун, аз жаргалтай байж билээ.

Асуулт:


1. Гэр бүлийн гишүүд энэ ажилд ямар оролцоотой байсан бэ? Хэн оролцоогүй вэ? Яагаад?
2. Гэр бүлийн гишүүд яагаад аз жаргалтай байсан бэ?
3. Гэртээ засвар хийхэд хэдэн төгрөг зарцуулсан бэ? Бодож тооцоолоорой.



Хоёр өрөө байр засахад ойролцоогоор 17 боодол хананы цаас шаардлагатай. Хананы цаас 1 боодол нь 10 м байдаг. 1 боодол хананы цаас 7500 төгрөгийн үнэтэй. 17 боодол хананы цаас наахад хэрэглэсэн цавууны хэмжээ 2 кг. 1 кг цавууны үнэ 10000 төгрөг.



1. Холбогдох зургийг утгаар нь бүлэглэн ангилж, нэр өгөөрэй.
 - а. Хэрхэн ангилсан бэ? Яагаад?
 - б. Хэд ангилсан бэ? Ямар, ямар нэр өгсөн бэ? Учир нь?



2. Гэр бүл, гэр бүлийн гишүүн бүрт хэрэгцээ бий. Өөрийн хэрэгцээгээ хангахын тулд хэн, юу хийх вэ? Хүснэгтийг нөхөөд ярилцаарай.

Хэрэгцээ	Өөрийн тань оролцоо, хувь нэмэр
Хоол хүнс бэлтгэж, хэрэглэх	
Ном, дэвтэртэй байх	
Ус, цахилгаан хэрэглэх	
Бие биенээсээ тусламж, дэмжлэг авах	
Хайрлах, халамжлах	
Тоглох	



Гэр бүл болгон чинээлэг, аз жаргалтай, амар амгалан амьдрахыг хүсдэг. Үүний тулд аав, ээж болон насанд хүрсэн гишүүд ажил хөдөлмөр хийдэг. Аав, ээжийн ажил, хөдөлмөр олон янз. Жишээ нь, зарим гэр бүл өөрсдөө мал аж ахуй, газар тариалан, худалдаа наймаа зэргийг эрхэлдэг. Харин зарим гэр бүлийн аав, ээж нь төрийн байгууллагад болон аж ахуйн нэгжид ажилладаг.

Тэд цалин, орлоготой. Түүгээрээ гэр бүлээ тэжээж, хүүхдүүдийнхээ хичээл, сургалтад зарцуулж, гэр, байраа засварлах зэргээр хэрэгцээгээ хангадаг. Харин эмэг эх, өвөг эцэгт улсаас тэтгэврийн мөнгө олгодог. Хүүхдүүд хэдийгээр цалин, орлогогүй ч аав, ээжийнхээ хөдөлмөрлөж олсон орлогыг зарцуулахад саналаа хэлж болно. Мөн өөрийн болон гэр бүлийнхээ эд зүйлсийг арчлан хамгаалж, орлогоо арвижуулахад тусалдаг. Эдгээр нь гэр бүл дэх өөрийн (миний) оролцоо юм.

Асуулт:

1. Гэр бүлийн гишүүд яагаад ажил, хөдөлмөр эрхэлдэг вэ?
2. Танай гэр бүлийн гишүүд ямар ажил, хөдөлмөр хийж орлого олдог вэ?
3. Аав, ээж болон гэр бүлийн бусад гишүүний олсон орлогыг яаж, зөв зарцуулах талаар саналаа бичиж, хэлэлцэнэ үү.

Гэрийн даалгавар



1. Анги, хамт олныхоо талаар мэдээлэл цуглуулж ирээрэй. Тухайлбал, танай ангийн хүүхдүүд юу сонирхдог, ямар хичээлд дуртай байдаг, ангидаа юу хийж, бүтээх хүсэлтэй байгаа талаар ангийнхнаасаа асуугаарай.

2. Хичээлийн хуваариа бичнэ үү. Хичээлийн хуваариа мэдсэн байх нь ямар ач тустай вэ?

Хичээл	1 дэх өдөр	2 дахь өдөр	3 дахь өдөр	4 дэх өдөр	5 дахь өдөр

СЭДЭВ 3. БИ АНГИЙН ХАМТ ОЛНЫ ГИШҮҮН



Анги бол
бас бичил нийгэм юм.



Бидний ярилцах зүйл:

- Ангийн хамт олон хэрхэн зохион байгуулагддаг вэ?
- Хамт олны амжилтад яагаад гишүүн бүрийн оролцоо чухал вэ?

Түлхүүр үг: Хамт олон, хамт олны гишүүн



Сайн байцгаана уу, найзуудаа.
Би та бүхэнд өөрийн сурдаг 4^б
ангийнхаа тухай танилцуулж,
ярилцах гэсэн юм.



Намайг Халиун гэдэг. Би одоогоос гурван жилийн өмнө нэгэн сумын дунд сургуулийн 1^б ангийн сурагч болсон. Одоо бид 39-үүлээ 4 дүгээр ангидаа дэвшин суралцаж байна. Манай ангийн багшийг Гантуяа, ангийн ахлагчийг Саруул гэдэг. Анги удирдсан багш маань бидний сурлага, хүмүүжилд тусалдаг, зөвлөдөг.

Манай ангийнхан жил бүр ангийн ахлагчаа сонгодог. Мөн ангийн дүрмээ гаргаж мөрддөг.




Манай анги, манай хамт олон

Удахгүй манай ангийн хурал болно. Бид энэ хичээлийн жилийн зорилгоо хэлэлцэнэ. Би “эвсэг, найрсаг, бие биедээ байнга талархдаг хамт олон больёо” гэсэн зорилго тавих бодолтой байгаа.


Ангийн бүх сурагч бие биедээ чаддаг зүйлээрээ тусалж, хичээл хийх, дугуйланд сурах, ангийн ажилд оролцох зэрэгтээ чадварлаг байвал бид бүгдээрээ амжилттай суралцана гэж би боддог. Бас ангийн хамт олны зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө сурагч бүр өөртөө зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийг чармайх хэрэгтэй. Би “тусч хүүхэд болох” зорилготой.



1. Халиуны ангийн хамт олны зорилгыг дараах бүдүүвчид нөхөн бичээрэй.



2. Дээрх бүдүүвчээ ашиглан, асуултад хариулна уу. (Халиуны саналыг эргэцүүлээрэй)
- Энэ хичээлийн жилд танай анги ямар зорилго тавих нь зүйтэй вэ?
 - Ангийн сурагч бүрийн зорилго нь ангийн зорилготой яагаад холбоотой вэ?



Сурагчид завсарлагааг хэрхэн өнгөрүүлсэн бэ?



Анги бүр сурагчдаас бүрдэнэ. Ангийг багш удирддаг. Ангийн сурагчид өөр өөрийн онцлог, ялгаатай ч хамтран суралцдаг. Яагаад гэвэл ангийн хамт олон өөрийн гэсэн нэгдсэн зорилготой байдаг. (Энэ талаар хичээлийн эхэнд ярилцсан) Жишээ нь:

- Ангиараа зөв, сайн уншдаг болох;
- Дүрэмт хувцсаа өмсөх;
- Нэг ч сурагч сурлагаар хоцрохгүй байх;
- Сурагч бүр урлаг, спортоор хичээллэх гэх мэт.

Эдгээр зорилгодоо хүрэхийн тулд сурагч бүрийн оролцоо, хичээл зүтгэл нэн чухал.



1. Завсарлагааны үеийн зургийг ажиглаад зурагт дүрсэлсэн сурагчдын дүр, үйлийг тайлбарлаарай.
2. Сурагчид хичээлийн завсарлагааг хэрхэн өнгөрүүлснийг үнэлнэ үү. +, - тэмдэглэгээг ашиглаарай.

Зургийн үйл явдал	Завсарлагааг		Дүрмээ	
	Зохистой өнгөрүүлсэн	Зохисгүй өнгөрүүлсэн	Баримталсан	Зөрчсөн
.....
.....
.....
.....



Бид анги, хамт олны зохион байгуулалттай танилцлаа. Аливаа хамт олон тогтсон дэг ёсыг баримталдаг. Тухайлбал, ангид баримтлах дэгийг ангийн дүрмээр тогтоодог. Сурагч бүр хамт олны гишүүний хувьд ангидаа баримтлах журам, дүрэм гаргахад өөрийн саналаа нэмэрлэх нь зүйтэй.

Гаргасан дүрмээ баримтлах нь өөрийгөө болон бусдыг хүндэтгэж, өөрсдийн үйл ажиллагааг зөв зохион байгуулж байгаа хэрэг юм.

File Edit View Insert

Save Ангидаа хамтран суралцах дүрэм зохиоходоо дараах заалтаас ашиглаарай.

① Бусдыг бүдүүлэг үгээр үл гомдоох, нэр хоч өгөхгүй байх

⑤ Шударга бус хандахгүй байх, үл мэхлэх


② Бусдадаа туслан дэмжих

⑥ Өөрийнхөө зөв гэж үзэж буй зүйлээ бусдадаа нотлох

③ Зөв мэтгэлцэх

④ Хэлсэн үгэндээ эзэн байх

⑦ Бусдын санаа бодлыг хүндэтгэх





1. Санамжид буй заалтыг ашиглан “Ангидаа баримтлах” дүрмийг өөрсдөө зохиож, багаараа хэлэлцээрэй.
2. Ангийн булангаа өөрсдөө хийгээрэй. Баг тус бүр сугалаа сугалж, ангийн булангийн дараах зүйлсээс алийг нь шинэчлэх болон шинээр хийхээ сонгоно. Үүнд:

1. Ангийн танилцуулга (ангийн цомгоо оруулна)
2. Манай ангийн бахархал
3. Сурагчдын жижүүрийн хуваарь
4. Хичээлийн хуваарь
5. Хичээлээс гадуурх ажлууд
6. Мэдээлэл



3. Багийн ажилд хэрхэн оролцсон талаар өөрийгөө үнэлж бичнэ үү.

Танай багийн сонгосон ажил	Ямар санал хэн хэлсэн бэ?	Юу хийсэн бэ?
Багийнхаа ажлыг үнэлнэ үү		


4. Анги, хамт олныхоо ямар төрлийн ажилд оролцдогоо хүснэгтийн эхний баганад нөхөж бичээрэй. Дараа нь хичээл болон хичээлээс гадуурх ажилд хэрхэн оролцдог талаар өөрийн саналаа тэмдэглэнэ үү.

Ажлын төрөл (Жишээ)	Хичээл, хичээлээс гадуурх ажилд оролцох талаар өөрийн саналаа тэмдэглээрэй.
Хичээл хийх (хамтарч ажиллах, асуулт асуух, багийн ажилд оролцох, удирдах г.м)	
Ангиа цэвэрлэх	
Ангийн хуралд оролцох (үг хэлэх, санал гаргах, хурал удирдах г.м)	

5. Асуултад хариулаарай.

- а. Чи хичээлээс гадуурх ямар төрлийн ажилд сайн оролцдог вэ? Яагаад?
- б. Ямар төрлийн ажилд сайн оролцож чаддаггүй вэ? Яагаад?
- в. Эдгээр ажилд өөрийн оролцоог нэмэгдүүлэх нь ямар ач холбогдолтой вэ? Саналаа хэлнэ үү.

СЭДЭВ 4. СУРГУУЛЬ ДАХЬ МИНИЙ ОРОЛЦОО



Бидний ярилцах зүйл

- Танай сургуульд хэн, хэн ажилладаг вэ?
- Чи сургуулийнхаа амьдралд ямар үүрэг, оролцоотой байдаг вэ?

Түлхүүр үг: Би, хамт олон, сурагч, оролцоо



1. Зургийг ажиглаад асуултын дагуу ярилцана уу.
 - а. Ангийн зохион байгуулалт ямар байна вэ?
 - б. Сурагчид юу хийж байна вэ?
 - в. Яагаад сургуульд анги байдаг вэ?



Энэ бол манай
сургуулийн нэг
анги



Ангидаа бид юу хийдэг вэ?

Сургуулийнхаа түүхийг судлаарай



Сургууль нь нэг ёсны бичил нийгэм юм. Сургуульд багш, сурагчдаас гадна эмч, номын санч, галч, үйлчлэгч зэрэг олон хүмүүс ажилладаг. Сургууль бүхэн өөрийн гэх түүхтэй. Чи ч гэсэн сургуулийнхаа түүхийг мэдэж аваарай. Сургуулийн түүхийн талаар мэдэх хэн нэг хүнээс дараах зүйлсийг асууж ярилцаарай. Үүнд:



2. Хоёр, хоёроороо хамтран доорх хүснэгтийн асуултад хариулан нөхөж гүйцээгээрэй.



Сургуулийн ажилтнууд	Юу хийдэг вэ?	Чамд хэрхэн тусалдаг вэ?	Чи тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?
Захирал			
Сургалтын менежер			
Нийгмийн ажилтан			
Анги удирдсан багш			
Сургуулийн эмч			
Номын санч			
Жижүүр			
Үйлчлэгч			

3. Дүрмийн заалтыг зурагтай нь тохируулан холбож, ярилцаарай.



А Багш, ажилтнуудын шаардлагыг биелүүлж, завсарлагааг аюулгүй, тайван өнгөрүүлэх



Г Ангидаа болон гэртээ хийх даалгавраа цаг хугацаанд нь гүйцэтгэх



Б Ямар нэгэн зүйл тохиолдвол ангийнхаа багшид хэлэх



Д Хэрвээ ямар нэгэн шалтгаанаар хичээлээсээ хоцорвол “уучлаарай, орж болох уу?” гэж зөвшөөрөл авах



В Сургуулийн жижүүрээс эхлээд багш, ангийнхантайгаа мэндлэх



Е Хичээлийн хонх дуугарахаас өмнө ангидаа суудлаа эзэлсэн байх



Сургууль бүр уламжлалт ажлууд зохиодог. Тухайлбал, намрын спартакиад, урлагийн үзлэг, шинэ жилийн баяр, сургуулийн авьяастны өдөр, уран уншлага, бүжгийн тэмцээн, “Сурагч-миний нэг өдөр” гэх мэт. Сурагч бүр сургуульд зохиогдож байгаа үйл ажиллагаанд хамрагдах, идэвхтэй оролцох нь хүмүүжил, соёлын дараах ач холбогдолтой. Үүнд:

Авьяас, чадвараа хөгжүүлэх



Анги, хамт олон, сургуулийнхаа найз нөхдөөс суралцах



Хамт олны нэг гишүүн гэдгээ мэдрэх



Асуулт:


1. Танай сургуульд жил бүр зохиогддог уламжлалт ямар, ямар ажлыг чи мэдэх вэ?
2. Чи ямар ажилд, хэрхэн оролцож байсан бэ?
3. Сургуулийнхаа ажилд оролцох нь чамд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ?

БАТАТГАЛ

Гэр бүл, сургууль болгон өөрийн амьдрал, түүхтэй. Гэр бүлийн гишүүд харилцан туслалцаж, бие биенээ хайрлах, хүндэтгэх үүрэгтэй. Бидний гэр бүл бол бичил нийгэм юм гэдгийг ойлгосон билээ. Одоо бүгдээрээ “Сурагч ба гэр бүл, сургууль, хамтын амьдрал” бүлэг сэдвээр юу үзэж судалснаа цэгцлэн бататгая.



1. Бүдүүвчийг нөхөж бичээд, ярилцаарай.



2. Асуултын хариуг нөхөж бичээд хосоороо хэлэлцэнэ үү.

Сургуулийн үүрэг юу вэ?
.....

Сургуульд шийдвэр гаргадаг гол хүн
.....

Манай ангийн дэвшүүлсэн зорилго
.....

Сурагчид ямар дүрэм мөрддөг вэ?
.....

Хичээлийн жилийн эхэнд тэмдэглэдэг баяр
.....

Гэр бүлийг нэгтгэж байдаг гол зүйл
.....

3. Зургаас нэгийг сонгож, гарчиг өгөөд эх зохиогоорой.



Ивээлтэй


Ивээлт 4-р ангид сурдаг. 2 дүүтэй. Эцэг эхийгээ ажилдаа явсан үед гэрийнхээ зарим ажлыг хийж, дүү нараа цэцэрлэгт хүргэх, авах зэргээр тус дэм болно. Ангийн сурагчдаас Ивээлтийг сургуулийн сагсан бөмбөгийн дугуйланд суралцуулахаар нэрийг нь өгчээ.

Асуулт:

1. Ивээлт гэр бүлийн гишүүний хувьд ямар үүрэгтэй байна вэ?
2. Яагаад ангийхан нь түүнийг дугуйланд суралцуулахаар нэрийг нь өгсөн бэ?
3. Ивээлт ямар шийдвэр гаргах бол. Таамаглал дэвшүүлж ярилцаарай.

II. БҮЛЭГ: НУТГИЙН ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ

СЭДЭВ 1. МАНАЙ НУТАГ



Орон нутаг бол бидний суралцаж, амьдарч буй орчин юм.



Бидний ярилцах зүйл:

- Манай нутаг ямар онцлогтой вэ?
- Манай нутгийн хүмүүс ямар аж ахуй эрхэлдэг вэ?
- Нутгийн хүмүүсийн ёс заншлын онцлог

Түлхүүр үг: Нутгийн хүмүүсийн эрхлэх аж ахуй, соёл



Асуулт:

1. Зураг дээрх угсаатнуудыг нэрлэнэ үү.
2. Ямар угсаатан аль аймагт амьдардаг вэ?
3. Танай нутагт ямар үндэстэн, угсаатан амьдардаг вэ?
4. Тэдний дуу хөгжим, хувцас ямар онцлогтой байдаг вэ?



Асуулт:

1. Газрын зургаас харахад нутгийн аль хэсэгт амьдардаг хүмүүс ямар ажил, хөдөлмөр хийдэг онцлогтой байна вэ?
2. Танай нутгийн хүмүүс ямар, ямар ажил эрхэлдгийг танилцуулаарай. Та нар тэдний ажил, хөдөлмөрт хэрхэн тусалдаг вэ?



Манай нутагт уул, тал хээр, говь байдаг. Эдгээрийг газрын зурагт өнгөөр ялгаж зурдаг. Уул болон уулархаг газрыг тод хүрэн, тал хээр болон говийг цайвар шар өнгөөр зурсан байдаг.

Ховор, үзэсгэлэнтэй байгаль, амьтан, ургамалтай газрыг улс, орон нутгаас тусгай хамгаалалтад авдаг. Үүнийг тусгай хамгаалалттай газар гэдэг.

Одоо бүгдээрээ зарим нэг аймгийн газрын зурагтай танилцаад асуултад хариулцгаая.





Хүүхдүүдийн яриаг уншаад асуултад хариулаарай.




Энэ манай аймгийн газрын зураг байна. Одоо бүгдээрээ манай аймаг Монгол улсын хаана байдаг, хэдэн сумтай, бусад ямар аймагтай хиллэдгийг нягтлая.



За тэгье. Увс аймаг Монгол улсын баруун хойд хэсэгт байдаг юм байна. 19 сумтай, хамгийн том газар нутагтай нь Давст сум байна шүү. Бас бусад аймгийн газрын зургаас уншиж мэдсэн зүйлээ дэвтэртээ тэмдэглэцгээе.


Увс аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутаг



Асуулт 1.

- Увс аймагт тусгай хамгаалалттай ямар газрууд байна вэ? Ямар сумын нутагт байна вэ?
- Та бүхэн өөрийн нутагт байгаа тусгай хамгаалалттай газрыг нэрлэнэ үү.
- Тэнд очиж үзсэн үү? Тэнд ямар сонин зүйл байдаг бол...

Сэлэнгэ аймгийн газрын сангийн зураг



Асуулт 2.

- Сэлэнгэ аймгийн газрын гадарга нь уулархаг байна уу, талархаг байна уу?
- Танай аймгийн газрын гадаргын онцлог юу вэ?
- Уулархаг болон талархаг газар нь нутгийн хүмүүсийн эрхлэх аж ахуй, амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ? Таны бодол...

СЭДЭВ 2. БИДЭНД ҮЙЛЧИЛДЭГ ГАЗРУУД



Хүмүүс орон нутагтаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн амьдардаг.



Бидний ярилцах зүйл:

- Танай нутагт үйлдвэрлэл, үйлчилгээний ямар газрууд байдаг вэ?
- Үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд нь хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?

Түлхүүр үг: Үйлчилгээний газар, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүмүүсийн хөдөлмөр



1. Зурагт ажиллаарай.



а. Дэлгүүрт янз бүрийн хүмүүс ажил хийж байна. Хэн, юу хийж байгааг ажиглаж, дараах хүснэгтийг нөхөж бичээрэй.

Дэлгүүрт ажилладаг хүмүүс	Ямар ажил хийж байна вэ?


б. Дэлгүүрт яагаад ийм олон хүн ажиллаж байна вэ?

в. Дэлгүүрт маш олон төрлийн бараа, бүтээгдэхүүн байна. Юуг, хаана үйлдвэрлэснийг нь бид хэрхэн мэдэх вэ?




Шошго

2. Бараа бүтээгдэхүүн бүр шошготой байдаг. Шошгон дээрх мэдээллийг унших нь ямар ач холбогдолтой вэ?



3. Зургийг ажиглаад ярилцаарай. Юуг, хаанаас авдаг вэ?



4. Зургийг ажиглан, бидний өмсөж хэрэглэдэг ноолууран цамцыг хэрхэн үйлдвэрлэдэг талаар зохиомж бичээрэй.



5. Танай нутагт ямар бараа, бүтээгдэхүүнийг голлон үйлдвэрлэдэг вэ? Энэ бараа, бүтээгдэхүүнийг хэн үйлдвэрлэдэг вэ?



1. Дараах үйлчилгээний газруудаас сонгон, бидэнд ямар үйлчилгээ үзүүлдэг болон ямар мэргэжлийн хүмүүс ажилладаг тухай бичээрэй.

Үйлчилгээний газрууд	Бидэнд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	Ямар хүмүүс ажилладаг вэ?
Банк		
Үсчин		
Шүдний эмнэлэг		
Театр		

2. Үйлчилгээний газраар соёлтой үйлчлүүлэх нь тэнд ажиллаж буй хүмүүсийн хөдөлмөрийг хүндэтгэж байгаа хэрэг юм. Нийтийн тээврийн унаанд үйлчлүүлэгчдэд хандан дараах санамжийг өлгөсөн байв. Та нар үйлчилгээний байгууллагаар соёлтой үйлчлүүлэх тухай өөрсдийн санамжийг бичээрэй.



Зорчигчдын анхааралд



- Өндөр настай хүнд суудал тавьж өгөөрэй.



- Үйлчилгээний төлбөрөө төлж үйлчлүүлээрэй.




- Эд, зүйлсээ алдахаас болгоомжлоорой.

- Хог бүү хаяарай.




Гэрийн даалгавар

Дараах тэмдэглэгээнүүд ямар утга илэрхийлсэн болохыг тайлбарлаарай.



СЭДЭВ 3. НУТГИЙН АМЬДРАЛД ХҮҮХЭД БИДНИЙ ОРОЛЦОО



Орон нутгийн хөгжилд хүүхэд бүрийн оролцоо чухал.



Бидний ярилцах зүйл:

- Аливаа үйл ажиллагаанд оролцохын ач холбогдол юу вэ?
- Нутаг орноо хөгжүүлэхэд хүүхэд бид хэрхэн оролцдог вэ?

Түлхүүр үг: Оролцоо



Монголчууд нүүдлийн мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг. Хавар төл мал хүлээн авах, тариа тариалах, намар хадлан бордоо бэлтгэж, тариа ногоо хураах зэрэг их ажил өрнөдөг. Зуны дэлгэр цагт малын сүү, цагаан идээ боловсруулдаг. Хүүхэд бид нар гэр бүл, өрхийн аж ахуйдаа өөрийн хувь нэмрээ оруулдаг.

Асуулт:

1. Та бүхэн гэртээ, сургуульдаа, орон нутагтаа ямар, ямар үйл ажиллагаанд оролцдог вэ?
2. Аливаа үйл ажиллагаанд оролцоход ямар сайн тал, ямар бэрхшээл байдаг вэ?



а. Багаар зохион байгуулагдан дараах мэдээллээс сонгоорой. "Нутгийнхаа амьдралд бидний оруулах хувь нэмэр" сэдвээр танилцуулга бэлтгээрэй.

б. Баг бүрийн танилцуулгаар үзэсгэлэн гаргаарай.

1. Сумын төвөөс Сугар охин аав, ээждээ туслахаар иржээ. Өглөөний нартай уралдан, илүү гэртээ хашсан ишгээ эхэд нь нийлүүлэхээр яаравчиллаа. Мал төллүүлэх нь нүүдэлчин ард түмний олон зуун жилийн турш хийж ирсэн уламжлалт ажлын нэг юм. Авсан төлөө онд мэнд оруулах, малаа өсгөх нь малчдын амьжиргааны эх үүсвэр болдог. Малчин ардын хүүхдүүд төл хүлээн авах ажилд идэвхтэй оролцдог.

- Төл хүлээж авах ажил хэдийд болдог вэ?
- Та нар яаж оролцох вэ? Саналаа бичээрэй.

Мал төллөх үеэр



Хадлан тэжээл бэлтгэх



2. Бид малчдад зориулж тэжээл бэлтгэдэг. Ингэхдээ давс, хужир, ясны гурил, шохой, аргалын үнс, сүрэл, агь, хүмүүл ашигладаг. Хадлан бэлтгэхэд машин техник зайлшгүй хэрэгтэй ч малчид гар аргаар тэжээл бэлтгэдэг.

-Танай нутагт малын гар тэжээл бэлтгэдэг ямар арга байдаг вэ? Олж мэдээрэй.

Мод, цэцэг тарих



3. “Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

2010 онд Ерөнхийлөгчийн Зарлигаар “Мод тарих үндэсний өдөр”-тэй болсон билээ. Энэхүү өдөр нь жилд 2 удаа буюу 5, 10-р сарын 2 дахь 7 хоногийн бямба гарагт юм. Энэ өдөр та бүхэн нэг ч гэсэн мод тарьж, түүнийгээ арчилж ургуулаарай”.

-Мод цэцэг тарих зөвлөгөөг найздаа бичээрэй.

4. Орчин үед хог хаягдал газар сайгүй бий болсон. Хогийг зүгээр л газарт булж орхиод байвал эцэст нь хогон уулнууд үүсэх нь гарцаагүй. Бид аливааг зохистой хэрэглэхэд суралцаж, хэрэглэж дууссанаа хаяхгүй дахин боловсруулан ашигладаг болох ёстой. Ялангуяа, лааз, хуванцар лонх зэргийг дахин боловсруулж бүтээгдэхүүн болгодог.

-Хаягдал хэрхэн боловсруулж ашиглах вэ? Өөрийн болон гадаад улсын туршлагаас олж танилцуулга бэлтгээрэй.

Нийгмийн тустай хөдөлмөр



Хүүхдүүд өөртөө хэрэгтэй мэдээллийг олж авснаар өөрийгөө хөгжүүлэх, санаа бодлоо илэрхийлэхэд суралцдаг. Энэ нь гэр бүл, сургууль, олон нийтийн орчинд өөрсдөдөө хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад, оролцоход дэмжлэг болдог. Олон төрлийн үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулах, санал, бодлоо хэлэлцэх зэргийг хүүхэд бидний оролцоо гэдэг.



Зургийг ажиглаад хүүхдүүд ямар үйл ажиллагаанд оролцдог талаар ярилцаарай.



Манай нутагт хүүхэд бидний төлөө үйл ажиллагаа явуулдаг олон байгууллага байдаг. Тэдгээр байгууллагын ажилтан ах, эгч нар орон нутагтаа, хүүхдийн хөгжих, боловсрох ээлтэй орчинг бий болгодог. Тэд бидний эрүүл, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажилладаг.



Гэрийн даалгавар

Нутгийнхаа байгаль, орчныг хэвийн байлгахад "Миний оруулах хувь нэмэр" сэдвээр дараах даалгавраас сонгож хийгээрэй.

1. Эх зохион бичээрэй. (30 үгтэй)

2. Дүрслэн зурж үзүүлээрэй.

СЭДЭВ 4. ӨӨРТ ХЭРЭГТЭЙ МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ОЛЖ АВАХ ВЭ?



Бидний амьдралд
мэдээлэл чухал
үүрэгтэй.



Бидний ярилцах зүйл:

- Мэдээлэл гэж юу вэ?
- Мэдээллийг хаанаас, хэнээс, хэрхэн олж авдаг вэ?

Түлхүүр үг: Мэдээлэл, мэдээллийн хэрэгсэл



Сонин

Хүн бүр авьяастай.
Авьяасгүй хүн гэж
байдаггүй.




Ном

Хүний авьяас:


- Танин мэдэх
- Урлаг
- Спорт
- Уран бүтээлийн үйл ажиллагаагаар хөгждөг.

TV- Боловсрол суваг

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй «Эрдэм, боловсролтой монгол хүн» хөтөлбөрийн дагуу сургууль, цэцэрлэгүүдэд «Авьяас» хөтөлбөр хэрэгжиж байна.



Өөрийн
авьяасыг хэрхэн
нээж хөгжүүлэх вэ?



Радио

Хүн бүр ямар нэг авьяастай төрдөг. Харин авьяасыг нээж хөгжүүлэхэд хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр, нөр хөдөлмөр хэрэгтэй.



Интернэт

Олон улсын хүүхдийн наадамд урлагийн шилдгүүдийг шалгаруулдаг тул урлаг, спортын авьяастай 63 хүүхэд, 14 дасгалжуулагчийн хамт мөдхөн ОХУ-ыг зорино.
www.assa.com



Сэтгүүл

Сур: Та ямар авьяастай вэ?
М: Би багаасаа л тоо бодох дуртай хүүхэд байсан. «Тоо бодоход толгой сэргэдэг» гэж өвөг аав минь хэлдэг байв. Аав, ээж, багш нар маань ч ойлгож, их дэмждэг, магтдаг байсан.

Асуулт:

1. Авьяасын тухай мэдээллийн ямар, ямар хэрэгсэлд юу, юу гэж мэдээлснийг ярилцаарай.
2. Мэдээллийн хэрэгсэл тус бүрд байгаа авьяасын тухай мэдээллийг нэгтгэн "Авьяас гэж юу вэ?" сэдэвт эргэцүүлэл бичнэ үү.



Нийгэм, соёл, хүмүүс, байгаль орчин, технологи болон чухал үйл явдлын тухай мэдээ, тоо баримт зэрэг нь мэдээлэл юм. Мэдээллийг телевиз, радио, сонин, сэтгүүл зэрэг эх сурвалж буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ)-ээс олж авдаг. Хүмүүс төрөл бүрийн мэдээлэл олж авснаар өөрийгээ хөгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, мэдээлэл нь нийгэм, орчин тойрноо танин мэдэх, мөн нутгаа хөгжүүлэхэд оролцох зэрэг олон талын ач тустай.

Мэдээлэл олж авах чухал эх сурвалжийн нэг нь ном юм. Иймээс сурагч та бүхэн номтой нөхөрлөж, номын сангаар үйлчлүүлж сурах нь чухал. Номын санд төрөл бүрийн ном хэвлэл, сонин, сэтгүүл, цахим хэрэглэгдэхүүн зэрэгтэй танилцаж болно.

Асуулт:

1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) гэдэг ойлголтыг тайлбарлана уу.
2. Та өөрт хэрэгтэй ямар мэдээллийг хэвлэл мэдээллийн ямар хэрэгслээс олж авахыг илүү сонирхдог вэ?



Манай сургуулийн номын санд олон сайхан ном байдаг.

Сургуулийн номын сангаар аялах санамж

Сургуулийнхаа номын сангаар аялцгаая



Сургуулийн номын санчтай уулзаж, аялалынхаа тухай танилцуулж, тохиролцоно.



Номын санд хэрхэн аялахаа ярилцаж, шийднэ. Тухайлбал, багт зохион байгуулагдан дараах зүйлсийг ажиглаж, номын санчаас асууж болно. Үүнд:

Асуух зүйл:

- Манай сургуулийн номын санд ямар, ямар төрлийн ном, сурах бичиг байдаг вэ?
- Бид хэрхэн уншигчийн карт нээлгэх вэ?

Ажиглах зүйл:

- Номын сангийн цагийн хуваарь
- Ямар ном, сурах бичиг хаана нь байрладаг
- Номын сангийн лавлах карт хаана байдаг, түүнийг хэрхэн ашиглах
- Номын сангийн суудлын тоо хэд вэ? гэх мэт.

- Баг бүр хийсэн ажлаа танилцуулна.
- Сургуулийн номын сангаас авч унших номын жагсаалтыг сурагч бүр гаргаж, тэдгээр номоо бие даан уншина.



Суут хүмүүс ном их уншдаг



Хүн мэдсэн, уншсаныгаа хэрээр аливааг ухаарч хардаг. Харж байгаагийн хэрээр боддог, бодож байгаагийн хэрээр хийж чаддаг. Суут хүмүүс ийнхүү уншиж, сэтгэж, бүтээдэг. Өөрийн оюун ухаан, эд хөрөнгө, цаг хугацааны аль боломжтойд нь түшиглэн, номоос ертөнцийг үзэх үзэл, харах хараагаа тэлж, хожим илүү ихийг бүтээнэ.



Зохиолчтой уулзалт хийж байгаа нь

Асуулт:

1. Энэ эхээс өөрт хэрэгтэй ямар мэдээллийг олж авсан бэ? Өөрийн үнэлэлтийг хэлнэ үү.
2. Суут хүмүүс ямар авьяастай байдаг вэ? Таны бодол?
3. Та хамгийн сүүлд ямар ном уншсан бэ? Номд гарсан шинэ мэдээллийг ширээнийхээ найзтай солилцоорой.



Гэрийн даалгавар


Танай гэр бүлийнхэн голлож хаанаас мэдээлэл олж авдаг вэ? (Голлож мэдээлэл олж авдаг 3 хүртэлх зүйлийг дугуйлж, тэдгээрийг жагсааж бичээрэй.)

- а. сонин, сэтгүүл, б. ном в. телевиз г. яриа, ярилцлага д. интернэт

БАТАТГАЛ



1. Нутгийнхаа улсын хамгаалалтад авсан түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай ярилцаж, тэмдэглээрэй.




Нутгийн түүх, соёлын дурсгалт газруудыг нэрлэ.

.....

Байгалийн үзэсгэлэнт газруудыг зурагт тэмдэглэ.

.....

2. Өөрийн нутгийнхаа зан заншил, өвөрмөц онцлогийн тухай хосоороо ярилцаад тэмдэглэл хөтлөөрэй.



A. Бичиг, соёлын дурсгал

B. Угсаатны байршил

B. Дуу, хөгжим, урлагийн

3. Өөрийн дүүрэг, сум, аймгийн тухай дэлгэмэл бяцхан ном бүтээж найз нартаа танилцуулна уу. (Тухайн нутгийн газрын зураг, гадаргын хэлбэр, ёс заншлын тухай мэдээлэл бэлдээрэй)

Манай нутгийн газрын зураг энд байна. Бид энд амьдардаг.	Манай нутгийн газрын гадарга ийм байдаг.	Манай нутгийн ёс заншил бусад нутгаас ялгаатай.	Эдгээр газрууд орон нутгийн хамгаалалтад байдаг.



Улсын Үндэсний номын санд XIX зууны үеийн Монгол дархчуудын бүтээсэн олон ном байдаг. Эдгээрээс мөнгөн хуудсанд үсгийг товойлгон бичиж, бурхдын хөргийг алт болон есөн эрдэнээр бүтээсэн Сундуйн жүд, Ганжуур, Данжуур зэрэг үнэт ном, бүтээлийг нэрлэж болно. Эд бол хосгүй үнэт өв юм.

Асуулт:

1. Монголчууд номыг юугаар, хэрхэн бүтээж байсан бэ?

III. БҮЛЭГ: ХУВЬ ХҮН БА ХҮМҮҮСИЙН (НИЙГМИЙН) ХАМТЫН АМЬДРАЛ

СЭДЭВ 1. БИД ӨӨР ӨӨРИЙН ОНЦЛОГТОЙ, БАС АДИЛХАН



Хүн бүр өөр өөрийн онцлогтой ч хамтран суралцаж, ажиллаж, амьдарч байдаг.



Бидний ярилцах зүйл:

- Хүмүүс яагаад өөр өөр байдаг вэ?
- Миний бусдаас ялгаатай болон адил тал юу вэ?
- Хувь хүн хэрхэн нийгмийн гишүүн болдог вэ?

Түлхүүр үг: Хувь хүн



1. Өөрийнхөө хамгийн сайн зан чанарыг жагсаан бичнэ үү.

Миний хамгийн сайн зан чанар.

Яагаад энэ зан чанарыг нэрлэх болсон шалтгаанаа бичнэ үү.

○ 1 _____

○ 2 _____

○ 3 _____

○ 1 _____

○ 2 _____

○ 3 _____

2. Найздаа танилцуулаарай. Та хоёрын сайн зан чанар адил байна уу, өөр байна уу? Яагаад?



Бид өөрсдийгөө хувь хүн гэдгээ, өөрийн хувь онцлогоо яаж танин мэдэж болох вэ? Өөрийнхөө онцлогийг танин мэдэх нь хувь хүн гэдгээ ухаарах, өөрийгөө хүндлэх, илэрхийлэх, бусадтай сайн харилцах зэрэг олон талын ач тустай байдаг. Өөрийгөө хэр сайн таньж, илэрхийлнэ, тэр хэмжээгээр хүмүүс чамтай харилцах болно. Өөрийгөө хүндлэх гэдэг нь өөрийгөө эерэг үнэлэх,

өөрийнхөө тухай эерэг бодохыг хэлдэг. Зарим хүн өөрийгөө эерэг үнэлж байхад, зарим хүн өөрийгөө сөрөг үнэлж байдаг. Одоо бүгдээрээ өөрийгөө эерэг үнэлдэг, мөн сөрөг үнэлдэг хүний дүр төрхтэй дараах хүснэгтээс танилцъя.



Өөрийгөө эерэг үнэлдэг
хүний дүр төрх:

- Байнга “Би чадна” гэж ханддаг.
- Хүмүүстэй танилцах дуртай.
- Шинэ учрал бүхэнд баярладаг.
- Хүмүүс өөртэй нь хамт байхад дуртай.
- Хүмүүс ойлгохгүй байсан ч өөрийнхөө зөв гэсэн зүйлийг хийдэг.
- Санаа бодлыг нь хүмүүс анхааралтай сонсдог.
- Аливаа зүйлийн сайн талыг үргэлж олж хардаг.
- Өөрт эерэг боломжийг ашиглаж чаддаг.



Өөрийгөө сөрөг үнэлдэг
хүний дүр төрх:


- Ихэнх зүйлд “Би чадахгүй байх” гэж боддог.
- Өөртөө итгэлгүй.
- Ажлаас их шантардаг.
- Өөрийнхөө алдааг уучилдаггүй, харин өөрийгөө шийтгэдэг.
- Хүмүүс шоолно гээд өөрийн бүтээлч санааг тэдэнтэй хуваалцахаас эмээдэг.
- Өөртөө сэтгэл хангалуун бус, өөрийгөө голдог.
- Ихэнх цагаа ганцаараа өнгөрөөдөг.
- Үргэлж гомдоллож, бусдыг шүүмжилдэг.

Асуулт:

1. Өөрийгөө үнэлэх, хүндлэх талаар юу ойлгосон бэ?
2. Өөрийгөө эерэг болон сөрөг үнэлдэг хүний дүр төрхийн талаар жишээ гаргана уу.



Энэхүү “Мод”-ны мөчир бүрд өөрийн давуу ба сул талыг бичиж зураглал хийгээрэй.



Эрт урьдын цагт Энэтхэгт нэгэн ус зөөгч 2 хувин бүхий дамнуургаар ус зөөдөг байжээ. Харин түүний 2 хувингийн нэг нь цоорхой тул усных нь тал асгардаг байв. Үүнээсээ цоорхой хувин нь ичиж, харин бүтэн хувин нь өөрөөрөө бахархана. Ийнхүү бүтэн 2 жил өнгөрөхөд, цоорхой хувин тэсч чадалгүй:

-Эзэнтэн минь би өөрөөсөө ихэд ичиж байна. Мөн танаас уучлалт гуйя гэжээ.



-Яагаад? гэж ус зөөгч асуухад:

-Яагаад гэвэл би аваачих усныхаа дөнгөж талыг нь аваачдаг. Миний ийм байдлаас болж, та авах ёстой хөлсөө бүгдийг нь авдаггүй гэхэд ус зөөгч хариуд нь:

-Чи буцахдаа замын хажуу талын цэцгүүдийг хараарай гэв. Цоорхой хувин буцахдаа замаа хартал үнэхээр сайхан цэцгүүд ургасан байв. Гэсэн хэдий ч хүрэх газраа хүрэхэд бас л тал устай байсан болохоор ус зөөгчөөс дахин уучлалт гуйв. Тэгэхэд ус зөөгч цоорхой хувингаасаа:

-Замын хажууд зөвхөн чиний талд л цэцгүүд ургасан, харин бүтэн хувингийн талд цэцэг ургаагүйг ч ижиглав уу хэмээн асуув:

-Үүний учир нь чамайг цоорхой болохоор би чиний талын замын хажуугаар цэцгийн үр суулгадаг байсан. Ус зөөх замд ч тэднийг усалж, сайхан цэцгүүд ургасан. 2 жилийн турш би энэ цэцгүүдээс түүж, эзнийхээ гэрт тавьдаг байлаа. “Хэрвээ энэ сайхан цэцгүүд байгаагүй бол манай эзний гэрт аз жаргал ирэхгүй байсан шүү дээ” хэмээн өгүүлжээ.

Асуулт:

1. Ус зөөгч замын хажуугаар цэцэг ургуулах арга, ухааныг хэрхэн бодож олсон бол?
2. Цоорхой хувингийн санаа зовсон шалтгаан юу вэ?
3. Ус зөөгчийн сайхан сэтгэлийн талаар ярилцана уу.

Дасгал

1. Зааврын дагуу дасгалыг гүйцэтгэнэ үү.
2. Дасгалыг гүйцэтгэсний дараа уг дасгалыг гүйцэтгэж байх үед төрсөн бодол, сэтгэгдэл, мэдрэмжээ ярилцаарай.

1. Ангийн сурагчид хоёр эгнээ болон өөд өөдөөсөө харж сууна. Нэг сурагчийн нүдийг боож, тухайн эгнээний дундуур явуулахад, бусад нь түүнтэй мэндлэх, мөрийг нь алгадах, нөхөрсгөөр тэврэх, магтан чанга инээмсэглэх зэрэг үйлдэл хийнэ.

2. Тухайн сурагч ангийн бүх сурагчийг бие биенийхээ тухай нэг сайн зүйл цаасанд бичихийг хүснэ.

3. Тэгээд сурагчид тэр бичсэн зүйлээ нүдээ боосон сурагчийн нуруунд цувруулан наана.

Хувь хүний нэг чухал онцлог нь түүний оюун ухаан, авьяас чадварын хөгжил, манлайлал юм.

- Өөрийхөө бусадтай адил талыг мэдрэх
- Өөрийгөө болон бусдыг таньж мэдэх
- Өөрийн онцлог, давуу талаа илрүүлэн, дайчилж, бусдын төлөө зориулах
- Зайлшгүй шийдвэрлэх асуудлыг олох, түүнийгээ шийдвэрлэх зөв арга, хандлага хэрэглэж, бусдыгаа үлгэрлэх, бусдыгаа хошуучлах зэрэг нь хувь хүний (чиний) манлайлал юм. Чамд бусдыгаа манлайлах, үлгэрлэх сайн чанар, чадвар, олон давуу тал бий. Эдгээрийгээ өөрөө таньж, хөгжүүлээрэй.






Гэрийн даалгавар

1. Хувь хүн, түүний өвөрмөц онцлогийг өөрийн үгээр тайлбарлана уу.
2. Хувь хүний онцлог болон нийтлэгийн талаар мэдсэн, мэдэхийг хүсч буй зүйлээ дараах хүснэгтэд бичээрэй.

<i>Хувь хүний онцлогийн талаар</i>		<i>Хувь хүний нийтлэгийн талаар</i>	
Мэдсэн зүйл	Мэдэхийг хүсч буй зүйл	Мэдсэн зүйл	Мэдэхийг хүсч буй зүйл

3. Дараах зургуудыг ажиглаж, аль нь, ямар үйл болохыг тодруулж, тус тус нэр өгөөрэй.



СЭДЭВ 2. ХҮМҮҮС ХЭРХЭН ХАМТРАН АМЬДАРЧ, АЖИЛЛАДАГ ВЭ?



Хүмүүс хамтран
ажиллаж, хамтаараа
шийдвэр гаргадаг.




Бидний ярилцах зүйл:

- Хамт олон, бүлгийг юу нэгтгэдэг вэ?
- Хамтын шийдвэр гаргахын ач холбогдол юу вэ?

Түлхүүр үг: Хамтын амьдрал, бүлэг, харилцаа



Эрт үед хүмүүс овгоороо амьдарч байжээ. Овгийг хамгийн хүч чадалтай, туршлагатай хүн удирддаг байв. Тэрээр хоол хүнсээ олох, хуваарилах, гадны халдлагаас овгоо хамгаалахын зэрэгцээ овгийн дотор хэв журам сахиулж, хорио цээрийг даган мөрдүүлдэг ажээ. Овгийн доторх хэв журам, хорио цээрийг зөрчсөн хүмүүст хүнд шийтгэл оноон, овгоосоо хөөдөг байлаа.



Асуулт:



1. Яагаад эртний хүмүүс овгоос хөөгдөхийг хүнд шийтгэл гэж үзэж байсан бэ?
2. Өнөөдөр амьдралын нөхцөл эрс өөрчлөгдсөн. Тэгвэл хүн бусад хүнгүйгээр ганцаараа амьдарч чадах уу?



Хүүхдүүдээ бидний сайн мэдэх зохиолын баатар Робинзон Крузо болон Маугли, Үл мэдэх, түүний найзууд, Цасан гоо ба 7 одой хүүхэлдэйн киноны баатруудын зураг байна.



а. Зургийг ажиглан нийтлэг шинжээр нь хоёр баганад ялган бичиж, хэрхэн ялгаснаа тайлбарлаарай.



б. Тэднийг юу нэгтгэж байна вэ?

в. Яагаад хүмүүс хамтаар амьдардаг вэ? “Ганц мод гал болохгүй, ганц хүн айл болохгүй” хэмээх зүйр үгийн утгатай холбон тайлбарлаарай.




Хүмүүс хоорондоо харилцах, хамтран ажиллах, харилцан туслах зорилгоор нэгдэн өөрөөр хэлбэл, нийгмээр амьдардаг. Хүний амьдралын анхдагч орчин (нийгэм) нь гэр бүл юм. Гэр бүлдээ биеэ зөв авч явах, эцэг, эх, хүүхдүүд бие биедээ туслах, дэмжих нь хамтын амьдралын нэг хэлбэр юм.

Ийнхүү нийгэм нь хамт олон, бүлгээс тогтдог. Гэр бүл, ангийн хамт олон, залуу шатарчдын клуб, дуу, бүжгийн дугуйлан, сагсан бөмбөгийн баг, хүүхдийн мини парламент, бөхийн дугуйлан зэрэг нь бүгд нийгмийн албан, албан бус бүлгүүд юм.



1. Дээр дурдсан бүлгээс өөрийн харьяалагддаг бүлгийг сонгож, тухайн бүлгийнхээ тухай танилцуулна уу. Танилцуулга хийхдээ дараах зааврыг ашиглаарай.

- Танай бүлгийнхэн юу хийдэг тухай;
- Танай бүлгийн гишүүдийн гол зорилго, та бүхнийг нэг бүлэг болгон нэгтгэдэг зүйл юу болох тухай;
- Чи бүлгийнхнээсээ юу сурдаг, бас чамаас танай бүлгийнхэн юу сурдаг тухай танилцуулаарай.



2. Бид өдөр тутам олон хүнтэй харилцаж байдаг. Энэ нь бидний ойр дотны хүмүүс, төрөл садан, найз нөхөд, бас тохиолдлын үл таних хүмүүс ч байдаг. Ийм маягаар өөрийнхөө уулзаж, ярилцдаг бүх хүнийг нэрлэж болно. Энэ нь бидний харилцааны хүрээ юм. Өгсөн тойргийг ашиглан өөрийнхөө харилцааны хүрээг нэрлэж бичээрэй.



Хүн бүр нийгэмд үнэ цэнтэй байдаг. Манай анги, хамт олон сурагчдаас бүрддэг. Бидэнд сурагч бүрийн санал бодол чухал. Хэрэв сурагч бүр оюунлаг, бүтээлч, бие даан суралцдаг бол манай анги ч сайн, бүтээлч

байх болно. Хэрэв бүх анги "сайн" бол сургуулийг "сайн" сургууль гэнэ. Бид бүхнээс анги, сургууль, эх орны маань хөгжил ямар байх нь шалтгаална.

Асуулт:

1. Танай анги, хамт олон чухал асуудлаа хэрхэн шийдвэрлэдэг вэ?
2. "Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй" хэмээх зүйр үгтэй холбон тайлбарлана уу.

Саахалт айлын санаа нэг



Инжлээрэй

Дандар, Даваа хоёрыг адуугаа услаад буцах мөчид Болдын аав худаг дээр таарчээ. Өвгөн мориноосоо буухдаа нэлээд зэмлэнгүй

- Та нар яасан ёс мэддэггүй, жудаггүй жаалууд вэ? гэсэнд тэд
- За юу буруудчих нь энэ вэ? гэж гайхлаа.
- Та нарт аав, ээж чинь заагаагүй юу. Үүнээс хойш малаа услаад буцахдаа заавал ч үгүй онгоцоо усаар дүүргээд орхиж бай гэж хэлэв.
- Тэгж илүү ажил удахын хэрэг юу билээ гэж Давааг асуухад
- Ээ буруу хойшоо бол. Нутгийн ах дүүсийн эзэнтэй, эзэнгүй ангаж цангасан мал чиний дүүргэсэн усыг ууж цангаагаа гаргадаг юм... хэмээв.



Бид худгаас ус авч гэр бүлдээ тус дэм болдог.

Г.Ловорын "Саахалт айлын санаа нэг" өгүүллэгийн хэсгээс...

Асуулт:

1. Зохиогч энэ өгүүллэгийг яагаад "Саахалт айлын санаа нэг" хэмээн нэрлэсэн бэ?
2. "Айл хүний амь нэг, Саахалт айлын санаа нэг" хэмээх зүйр үгийн утгыг тайлбарлаарай.



Гэрийн даалгавар

1. "Айл хүний амь нэг, Саахалт айлын санаа нэг" хэмээх зүйр үгтэй ойролцоо утгатай зүйр үгсийг олж бичнэ үү.
2. Манай сургуульд жил бүр "Үндэсний хувцасаараа гоёцгооё" уламжлалт өдөрлөг болдог. "Үндэсний хувцасаа хэрхэн зөв өмсөх вэ?" гэсэн сэдвээр товч эргэцүүлэл бэлтгэж, ангийнхандаа танилцуулаарай.

СЭДЭВ 3. БИД ХАМТЫН АМЬДРАЛАА ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛДАГ ВЭ?



Хүмүүсийн хамтын амьдралыг үр ашигтай болгож буй зүйл нь зохион байгуулалт юм.



Бидний ярилцах зүйл:

- Хүмүүсийг юу нэгтгэдэг вэ?
- Хүмүүсийн хамтын амьдралын зохион байгуулалт гэж юу вэ?

Түлхүүр үг: Хүмүүсийн хамтын (нийгмийн) амьдрал, зохион байгуулалт

Бөмбөлөг улс



Инжлээрэй

Бөмбөлөг улсын тэнгэр цэлмэг, агаар нь тунгалаг, байгаль нь үзэсгэлэнтэй, хүмүүс нь үнэнч шударга, эв найртай байжээ. Тэр улсад ширвээ хар сахалтай, хүн бүрийн танил Далай гэдэг хүн байв. Бас түүний багын найз Даяндээрх хэмээх ямагт инээмсэглэж явдаг нэгэн. Даяндээрх бол их өөдрөг бодолтой хүн. Тэрээр Бөмбөлөг улс улам хөгжин дэвжиж, хүмүүс нь илүү их аз жаргалтай байгаасай хэмээн хүсэж, ирээдүйгээ гэрэл гэгээтэй төсөөлдөг.

Гэвч эл улс хүнд хүчир бэрхшээлтэй тулгарчээ.



Далай өгүүлсэн нь:

Олон айл өрх, олон аж үйлдвэр нүүрсээр галлах юм даа. Энэ их утааны нь балгаар хүмүүс, амьтад, ургамал амьсгалахад хэцүү боллоо. Агаарын бохирдлоос болж их хүйтрэх болж, хүмүүс ч даарч байна. Бөмбөлөг улсын маань орших гаригийн хий нь гарч, доош унан сөнөхөд тулах вий дээ.



Даяндээрх өгүүлсэн нь:

Хүмүүс эх гариг, байгаль орчин, эрүүл мэндээ хайрлахгүй юм даа. Амар хялбараар амьдрахыг бодож, буруу хооллож байна.



Далай өгүүлсэн нь:

Бүтэлгүй, муу хүмүүс олширох нь. Тэд хүний юмыг зөвшөөрөлгүй авч, бас ямар нэг юм хийхдээ бусдаас асуухгүй, зөвхөн, өөрт нь болж л байвал хүссэнээрээ хийж байна. Энэ хэцүү байдлыг яаж засч залруулах вэ?



Даяндээрх өгүүлсэн нь:

Бид Бөмбөлөг улсаа, хүмүүсээ аврахын тулд зохион байгуулалт хийхгүй бол

оройтох нь ээ. Улсынхаа бүх хүмүүсийг цуглуулж, юу хийх талаар ярилцъя. Ингээд бүгд цуглан хуралдаж гэнэ. Гэлээ ч цугласан хүмүүс шуугилдан, бие биеийнхээ яриаг сонсохгүй, эмх замбараагүй байсан тул



Далай өгүүлсэн нь:

Шуугилдахаа больцгооё!!! Одоо нэг нэгээрээ босч үгээ хэлцгээе. Бие биенээ сонсоцгооё. Хамгийн оновчтой шийдвэрийг хамтаараа гаргацгаая.



Даяндээрх өгүүлсэн нь:

Бид бүгдээрээ алдаагаа засъя. Бөмбөлөг улсаа аварцгаая. Үүний тулд хоорондоо эв найртай, зохион байгуулалттай байж, хамтран ажиллая.

Асуулт:

1. Бөмбөлөг улсад ямар бэрхшээл тулгарсан бэ?
2. Далай, Даяндээрх нар энэ бэрхшээлийн шалтгааныг юу гэж үзсэн бэ?
3. Улсаа аврахын тулд Даяндээрх ямар санал гаргасан бэ?
4. Та бүхэн Бөмбөлөг улсад байсан бол ямар санал хэлэх байсан бэ?
5. Даяндээрхийн саналыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?



Хүмүүс өөр, өөрийн онцлогтой, ондоо зан ааштай ч хүсэл, зорилго, санаа нэгдэн хамтран амьдарч, ажилладаг. Энэ нь тэдэнд нийтлэг хэрэгцээ, сонирхол байдагтай холбоотой. Хоол, хүнс, хувцас, орон байртай байх, бие биенээсээ суралцах нийтлэг хэрэгцээ нь хүмүүсийг нэгтгэдэг. Харин “Бөмбөлөг улс” тохиолдолд өгүүлсэн шиг хувь хүмүүс зөвхөн амиа бодож, дур дураараа, эмх замбараагүй байвал тэдний хамтач амьдрал оршин тогтнож, хөгжин цэцэглэхгүй. Иймээс хүмүүсийн хамтын амьдралд эмх цэгц, эв нэгдэл, зохион байгуулалт, удирдлага хэрэгтэй болдог. Бидний өмнө ярилцсан гэр бүл, сургууль, ангийн хамт олон бол хүмүүсийн хамтын амьдралын нэгдэл, зохион байгуулалтын тодорхой хэлбэр юм. Хүмүүсийн хамтын амьдралыг зорилго, чиглэлтэй, тогтвортой, үр ашигтай болгож буй арга, ухаан, эмх цэгцийг зохион байгуулалт гэдэг. Хамтын амьдралын зохион байгуулалтыг зөв чиглүүлж, манлайлж байгаа хүнийг удирдагч гэнэ. Жишээ нь, айл өрхийн тэргүүн, сургуулийн захирал бол тухайн хамтын амьдралыг зохион байгуулж, удирдаж буй хүмүүс билээ.

Асуулт:

1. Хүмүүсийг ямар зүйл нэгтгэдэг вэ? Тухайлбал, танай ангийн сурагчдыг ямар зүйл нэгтгэдэг вэ?
2. Хүмүүсийн хамтын амьдралын зохион байгуулалт гэж юу вэ? Хамтын амьдралын зохион байгуулалтын хэлбэрийн талаар жишээ гаргаарай.
3. Хүмүүсийн хамтын амьдралд бэрхшээл гардаг уу? Яагаад? Чиний бодол?

Дасгал. Зөв хариултын өмнөх үсгийг дугуйлаад хэлэлцээрэй.

Хүмүүсийн хамтын амьдралын зохион байгуулалтыг аль нь оновчтой илэрхийлж байна вэ?


а. Чухал шийдвэрийг хамтран гаргах

б. Хүмүүс өөрийн хүссэнээр амьдарч, ажиллах

в. Хүмүүсийн хамтын амьдрал зорилго, чиглэлтэй, эмх цэгцтэй байх

г. Зөв чиглүүлэх, манлайлах удирдагчтай байх

СЭДЭВ 4. БИДНИЙ ХАМТЫН АМЬДРАЛ БА ДҮРЭМ



Хүмүүс хамтран
амьдрахад дүрэм
тусалдаг.



Бидний ярилцах зүйл:

- Хүмүүс бид дэг журмаа хэрхэн мөрддөг вэ?
- Дүрмээ мөрдөөгүйгээс ямар хор уршиг гарах вэ?

Түлхүүр үг: Дүрэм, хариуцлага, зөрчил



а. Дараах дөрвөн цуврал зургаас сонгож эх зохионо уу. Эх зохиохдоо дараах үгсийг ашиглаарай.

- Манай гудамж
- Жагсаал
- Ногоон гэрэл, цагаан шугам
- Хичээлийн хонх

б. Зохиосон эхээ бие биедээ уншиж танилцуулаарай.



Хүмүүс бие биенээсээ ялгаатай бас санал бодол нь өөр өөр байдгийг бид мэднэ. Гэсэн ч тэд эмх цэгцтэй, эв нэгдэлтэй, зохион байгуулалттайгаар хамтран амьдардаг. Ингэж амьдрахад, өөрөөр хэлбэл, хүмүүс бие биенээ ойлгож, хамтран амьдрах, мөн аюулгүй байхад дүрэм тусалдаг. Дүрэм нь хүмүүс хоорондоо харилцах болон ямар нэгэн ажил, үйл хийхдээ баримтлах, зөвшөөрсөн эсвэл хориглосон заалтуудтай байдаг.

Дүрмийг хэлэлцэж гаргадаг бөгөөд энэ нь тодорхой үе шаттай. Дүрэм гаргахын тулд уг дүрмийг баримтлан ажиллах, мөрдөх ёстой хүмүүс болон байгууллагыг оролцуулж, саналыг нь авдаг. Ингэвэл тэд хамтарч гаргасан, санал өгсөн дүрмээ бүгдээрээ сайн биелүүлэх болно.

Дүрмээр хориглосон зүйлийг хийх нь зөрчил юм. Дүрэм зөрчсөн бол хариуцлага хүлээнэ. Жишээ нь, хүүхдүүд хөл бөмбөг тоглож байгаад айлын цонх хагалбал аав,

ээж нь цонхыг нь шиллэж хариуцлага хүлээдэг. Ахмад настан болон аав, ээж, багш нарынхаа үгэнд орохгүй буруу зүйл хийвэл зэмлүүлж шийтгүүлдэг. Харин замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч мөнгөөр торгуулахаас эхлээд машин жолоодох эрхээ хасуулах хүртэл хариуцлага хүлээдэг. Хүүхэд дугуйлангийн дүрмийг удаа дараа зөрчих юм бол тэр хүүхдийг дугуйлангаас хасаж болно.

Асуулт:

1. Дүрэм гэж юу вэ? Дүрэм бидний хамтын амьдралд ямар тустай вэ? Бидэнд ямар дүрэм байгаа вэ?
2. Дүрэм бидэнд хэрхэн тусалдаг вэ? Жишээ гарган ярилцаарай.
3. Бид дүрмийг яагаад заавал биелүүлэх хэрэгтэй вэ? Дүрмийг биелүүлэхгүй байх юм уу, зөрчвөл ямар үр дагавар гарах бол?



Багт хуваагдан дараах дүрмийн төсөлд саналаа өгөөрэй. Үүний тулд:

- а. Баг бүр дүрмийн төслийг сайтар уншаад дараах асуултад хариулж ярилцана. Үүнд:
 - Дүрмийн заалтууд юуг зөвшөөрч, юуг хориглосон байна вэ?
 - Танай багийн гишүүд аль заалтыг дагаж мөрдөхдөө баяртай байх вэ?
 - Та нар аль заалтыг өөрчлөх хэрэгтэй гэж бодож байна вэ? Яагаад?
 - Танай багийнханд энэ дүрмэнд нэмэх эсвэл хасах саналтай ямар заалт байна вэ?
- б. Баг бүр дээрх асуултад хэрхэн хариулснаа бусад багийнханд танилцуулаарай.

СУРАГЧИЙН МӨРДӨХ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРМИЙН ТӨСӨЛ

Нэг. Хичээлд ирэхдээ баримтлах дэг:

- а. Хичээлд ирэхдээ цэвэр хувцаслаж, тухайн өдрийн хичээлийн бэлтгэлийг бүрэн хангасан байна.
- б. Хонх дуугарахаас 30-иос доошгүй минутын өмнө ирсэн байна.
- в. Сурагч ямар нэгэн шалтгаанаар хичээлд ирээгүй бол энэ тухайгаа анги удирдсан багшид мэдэгдэж, шаардлагатай магадлагааг ирүүлнэ.

Хоёр: Сургууль, хичээлд баримтлах дэг:

- а. Хичээлээс хожимдох, хичээлийн явцад зөвшөөрөлгүй ангиас гарахыг хориглоно.
- б. Хичээлийн үеэр чанга дуугаар ярихыг хориглоно.
- в. Сурах бичиг, хичээлийн хэрэглэлээ цэвэр гамтай эдэлнэ.
- г. Сургуулийн номын сангийн номыг хугацаанд нь буцаан өгнө.





"Дүрэм ба хариуцлага" хүснэгтийг бөглөж ярилцана уу.

Дүрэм	Зөрчил	Гарч болох үр дагавар	Хариуцлага
Ногоон гэрлээр зам хөндлөн гарна.	Улаан гэрлээр гарсан		
Хонх дуугарахаар хичээл завсарлана.	Хонх дуугарахаас өмнө хичээл завсарласан.		
Дугуйлан Даваа, Пүрэв гарагийн 10.00 цагт эхэлж байна.	Сурагч 10.30 цагт дугуйландаа ирсэн.		

Дүрэмтэй болсон нь



Бид бүжиг, амьдрах ухаан зэрэг зарим хичээлийг нэмж судлах саналыг ангийн багшдаа тавилаа. Багш маань үүнийг ганцаараа шийдэж чадахгүй гээд бусад багш нар болон сургуулийн удирдлагатай (захирал, хичээлийн эрхлэгч) санал солилцсон юм. Бидний саналыг тэд зөвшөөрлөө.

Гэтэл манай ангийн болон бусад ангийн хүүхдүүд тийм ч хичээлийг сонгоно, тэрийг ч сонгохгүй гэж маргаан болов. Зарим хичээлийг олон, заримыг нь бүр ганцхан хүүхэд сонгожээ. Ганц хүүхдэд хичээл орох боломжгүй гэж сургуулийн захирал хэлэв. Ингээд хичээл сонгохыг сонирхож байгаа бүх хүүхдийн саналыг тусгасан дүрэм байх хэрэгтэйг бид ойлгосон юм.

Дүрэм гаргахын өмнө уг дүрмийн төслийг зохиох багийг багш, сурагчдын төлөөлөлтэйгээр байгуулав. Уг багийн гишүүн сурагчид, багш нар, сургуулийн захиргаа, эцэг, эхээс санал авч, дүрэмд оруулах заалтуудыг боловсруулсан юм. Ингээд дүрмийн төсөл бэлэн боллоо.

Дүрмийн төслийг анги тус бүрийн хурал болон багш нарын хурлаар хэлэлцүүлээд, батлав. Тэгээд захирал багш маань тушаал гарган баталгаажуулж, манай сургууль "Хичээл сонгож судлахад баримтлах дүрэм"-тэй болсон юм даа.



Асуулт:

- Хичээл сонгож судлахын тулд яагаад дүрэм хэрэгтэй болсон бэ?
- "Хичээл сонгож судлахад баримтлах дүрэм"-тэй болоход:
 - Ямар, ямар хүмүүс, ямар үүрэгтэйгээр оролцсон бэ?
 - Уг дүрэм ямар үе шатуудыг дамжин гарсан бэ? Үе шат бүрийн онцлогийг ярилцана уу.



Гэрийн даалгавар

"Багаар ажиллахын ач тус" сэдвээр зохион бичлэг хийгээрэй.

БАТАТГАЛ



1. Багаараа хамтарч хийгээрэй.
 - Өөрийн нутгийн ажил хөдөлмөрөөрөө алдаршсан хүмүүсээс судалж, ангидаа урина.
 - Ангийн сурагч бүр идэвхтэй оролцоорой. Дараах ажлуудыг багаар хуваагдан хийгээрэй. Уулзалт зохион байгуулахад хэн, хэрхэн оролцсоныг дараа нь үнэлээрэй.

1-р багийн үүрэг

1. Уулзалтын танхимд урьсан зочны хөдөлмөр, бүтээлтэй холбоотой зургийн үзэсгэлэн бэлтгэсэн байх.
2. Уулзалт дууссаны дараа урьсан зочиндоо талархал илэрхийлж, дурсгалын зураг татуулах.

2-р багийн үүрэг

1. Уулзалт амжилттай болоход ширээний хэлбэр чухал. Иймээс ширээгээ ямар хэлбэртэй засахаа сонгож ярилцаж, бэлдэх.
2. Урьсан зочдын нэрсийг жагсааж, суух ширээнд байрлуулах.

3-р багийн үүрэг

1. Уулзалтыг хөтлөх сурагчаа сонгох.
2. Уулзалтын үеэр тодруулж асуух асуултаа бэлтгэх, зочноо танилцуулж, ярилцлагаа эхлэх.

4-р багийн үүрэг

1. Зочиндоо хэзээ, хаана хүрэлцэн ирэх урилга хүргүүлэх.
2. Зочноо угтаж танхимд оруулж, хүндэтгэлийн суудалд суулгах, үдэх.

2. Уулзалтаас төрсөн сэтгэгдэл, тэмдэглэл хөтөлж, тэдгээрийг ангидаа байрлуулаарай.



3. Хэлэлцээрэй.

- а. Та нарын хооронд санал зөрөлдөх тохиолдол гардаг уу? Түүнийг хэрхэн шийдвэрлэдэг вэ? Та нар асуудлыг шийдвэрлэх дараах аргуудаас алийг нь сонгох вэ? Яагаад?
- б. Чиний бодлоор хүүхдүүд асуудлыг шийдвэрлэхдээ дараах зан байдлын алийг нь илүү илэрхийлдэг вэ? Яагаад?

Хошигнох	Заналхийлэх, хүч хэрэглэх
Буулт хийх	Бүдүүлэг авирлах, доромжлох
Харилцан буулт хийх	Асуудлыг шийдвэрлэхээс зайлсхийх
Хамтран ажиллах	Харилцаагаа таслах

Ү. БҮЛЭГ: ХУВЬ ХҮНИЙ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

СЭДЭВ 1. ӨӨРИЙН ҮҮРЭГ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН БИЕЛҮҮЛЭХ ВЭ?



Өөртөө үүрэг хүлээж, түүнийгээ биелүүлэх нь хувийн амжилтад нөлөөлдөг.



Бидний ярилцах зүйл:

- Хувь хүн өөртөө ямар үүрэг хүлээдэг вэ?
- Үүргээ биелүүлэхийн ач холбогдол юу вэ?

Түлхүүр үг: Өөртөө хүлээх үүрэг, бусдын өмнө хүлээх үүрэг, өөрийн төлөвшил



1. Тэргэл: Ээжээ, би хөөрхөн нохойтой болмоор байна.
Ээж: Хэрэв нохой авбал түүнийг өглөө, орой бүр салхинд гаргах болно. Өдөрт 2-3 удаа хооллоно. Бас хоолны сав, унтах газрыг нь цэвэрлэнэ. Мөн усанд оруулна. Энэ бүгдийг чи хийх болно.
Саруул: Ээжээ, би амлаж байна. Дүү, бид хоёр нохойгоо ээлжээр салхинд гаргаж, хооллож, усанд оруулж чадна.
Ээж: Та хоёрт үүрэг, хариуцлага нэмэгдэнэ дээ. Амлаж үүрэг хүлээх амархан ч түүнийг

биелүүлэх нь амар биш.



Асуулт:

1. Тэргэл, Саруул хоёр өөрсдөдөө ямар үүрэг хүлээсэн бэ?
2. Тэд ийм үүрэг хүлээснээр ямар сайн зүйлд хүрэх вэ?
3. Тэд ийм үүрэг хүлээснээр ямар боломжоо алдаж болох вэ? Чиний бодлоор?

2. Тооны хичээл дээр шалгалт авав. Гэтэл Мишээлийн дэвтэр дүүрчихсэн байв. Тэр нэг ширээнийхээ Тогмидоос дэвтэр гуйхад Тогмид гурван дэвтэр гаргаад, нэгийг нь өгөхдөө “Чи тоогоо хуулуулаарай” гэж аяархан хэлэв. Мишээл “Баярлалаа. Би маргааш өгье” гэснээс өөр



зүйл хэлсэнгүй. Сурагчид дор бүрнээ тоогоо бодож байхад ганцхан Тогмид л гиоүрэн сууна. Тэр Мишээлийг нударч “Нааш нь харуулаач” гэтэл “Тогмид оо, өөрөө бодоорой” гэж багш анхааруулав. Тогмид жижиг цаасан дээр “Тоогоо хуулуулбал дахиад нэг дэвтэр өгье” гэж бичээд Мишээлийн өмнө тавьчихав. Мишээл бичгийг уншаад жуумалзсанаа толгой сэгсрэв. Тогмид багшийн нүдийг хариулж байгаад

“Би дэвтрээ авмаар байна” гэж шивнэлээ. Мишээл Тогмидод “Би завсарлагаанаар олж өгье” гэв. Тогмид дахиад л “Би дэвтрээ одоо л авахгүй бол тоогоо бодож болохгүй байна” гэтэл багш түүнийг чимээгүй байхыг анхааруулав. Тогмид завсарламагц “Дэвтэр өгч байхад тоогоо хуулуулсангүй. Мишээл хувиа бодогч” хэмээн анги дүүрэн хашхирав.

Дараа нь уран зохиолын цаг дээр Тогмид тохойгоороо номоо халхлан ганцаараа уншиж байгааг харсан багш нь “Тогмид оо, чи яагаад хувиа бодоод хажуу дахь Мишээлдээ уншуулахгүй байгаа юм бэ?” гэхэд ангийнхан нь инээлдэв. Нөхдийнх нь жиг жуг инээх нь Тогмидод ичиг ичиг гэх шиг санагдаж, ихэд ичив.

Асуулт:

1. Тогмид өөртөө хүлээсэн ямар үүргээ биелүүлээгүй вэ? Яагаад? Чиний бодлоор?
2. Тооны хичээлийн шалгалтын тэр үед Мишээл Тогмидын өмнө үүрэг хүлээх ёстой юу яагаад?
3. Тогмид уран зохиолын хичээл дээр Мишээлд туслах ёстой үүргээ яагаад биелүүлээгүй вэ? Энэ талаар өөрийн үнэлэлт өгнө үү.



1. Итгэлт телевиз үзэхийн өмнө гэрийн даалгавраа хийж дуусгадаг.
2. Алимаагийн аав өглөө 8 цагт ажилдаа очсон байх ёстой.
3. Цолмон сургуулийн сагсан бөмбөгийн багт тоглодог. Тэр өдөр болгон хичээлийн дараа бэлтгэл хийдэг.

Асуулт:

- а. Хэн ямар үүрэг хүлээж байгааг тус тус ялган тайлбарлана уу.
- б. Эдгээр хүмүүс тухайн үүргээ биелүүлбэл тэдэнд ямар ач тустай вэ?
- в. Эдгээр хүмүүс тухайн үүргээ эс биелүүлбэл тэдэнд ямар сөрөг үр дагавар гарах вэ?



Хүн бүрд өөрийнхөө болон бусдын төлөө хийх зүйл байдаг. Хийх ёстой зүйлээ эзний ёсоор хийхийг үүрэг гэдэг. Жишээ нь, чи хичээлийн хэрэглээ байранд нь тавих ёстой. Энэ бол үүрэг. Тухайн хүн хийх ёстой зүйлээ хийх, хүлээсэн үүргээ сайн биелүүлбэл сайшаал, шагнал ч хүртэнэ, ажил, сурлагадаа ч амжилт гаргаж хөгжинө. Тухайлбал, үүргээ биелүүлсэн хэн нэгэн өөртөө итгэлтэй байх ба бас бусдаас сайшаал, магтаал, урамшуулал, хүндлэл хүлээнэ. Харин үүргээ биелүүлэхгүй бол өөрөөсөө ичих, өөртөө гэмших, бусдаас санаа зовох, бусад хүмүүсээс зэмлэл, шийтгэл хүлээх, өөрийн боломж, хөнгөлөлтөө алдах зэрэг олон сөрөг зүйлд хүрнэ. Хүмүүс өөртөө аль нэг үүрэг хүлээж, түүнийгээ биелүүлэхэд сайн болон сөрөг үр дагавар гардаг. Жишээ нь, тухайн сурагч сурагчдын зөвлөлийн гишүүн болох шийдвэр өөртөө гаргавал үзэл бодлоо илэрхийлэх, улмаар хувьдаа сэтгэл хангалуун байх зэрэг сайн, ашигтай үр дагаварт хүрнэ. Гэтэл чөлөөт цаг нь багасах, хүн бүрийн сэтгэлд нийцсэн санал, шийдвэр гаргах боломжгүй зэрэг сөрөг үр дагавар гарна.

Асуулт:

1. Үүргийн тухай өөрийн үгээр тайлбарлана уу.
2. Хүн өөртөө үүрэг хүлээхийн эерэг болон сул тал юу вэ? Чиний бодол?

СЭДЭВ 2. ДҮРЭМ БА ХАРИУЦЛАГА



Дүрэм нь хүн бүрийг үүрэг, хариуцлагаа биелүүлж, сайн хүн, сайн иргэн байхад тусалдаг.



Бидний ярилцах зүйл:

- Үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд юу тусалдаг вэ?
- Үүрэг, хариуцлага биелүүлэх нь яагаад чухал вэ?

Түлхүүр үг: Дүрэм, үүрэг, хариуцлага



1. Асуултын дагуу тэмдэглэл хөтөлж, ярилцаарай
 - а. Тэргэл, Саруул хоёр нохой тэжээх болсноор ямар үүрэг хүлээх болсныг санана уу.
 - б. Тэр хоёр үүргээ биелүүлэхийн тулд юу, юу хийх ёстой вэ?
 - в. Ээж нь ямар үед тэр хоёрыг “миний хүүхдүүд хэлсэндээ хүрдэг, хариуцлагатай, сайн хүүхдүүд” гэж магтан сайшаах бол? Харин ямар үед “миний хүүхдүүд хариуцлагагүй байна даа...” гэж сэтгэл дундуур байх бол?
2. “Дүрмийн тухай та бүхэн юу мэдэх вэ?” Багаар ажиллана уу.
 - а. Сэдвийн эхний зургийн дагуу багуудад хуваагдаарай.
 - б. Дүрс тэмдгийн дагуу танай багийнхан ямар үүрэг, хариуцлага хүлээх вэ? Жагсааж бичээд, бусад багийн хүүхэд бүрд танилцуулаарай.

Тэмүгэ хөдөө амарсан нь



Тэмүгэ: за, хөдөө гараад л ямар ч дүрэмгүй сайхан амрая байз.

Аав нь: Чи тэгж бодож байна уу? Зөвхөн хотод л дүрэм байдаг гэж үү?

Эгч нь: Чи сайн бодох л хэрэгтэй дээ. Гэхдээ тэнд ямар дүрэм байдгийг өвөө, эмээ, бусад хүүхдүүд чамд хэлээд өгөх байх л даа.



Хөдөөгийн замд: Тэмүгэ: Ааваа энэ ямар тэмдэг вэ?


Аав: Хурдаа хасаарай, мал, амьтан явдаг шүү гэсэн тэмдэг.

Тэмүгэ: Тийм байна, тэнд үхэр зам гарч байна.

Тэмүгэ: Энэ бас ямар тэмдэг вэ?

Аав нь: Одоо тойрно шүү, болгоомжтой бай гэж байна.

Тэмүгэ: Ээ, дураараа давхиж болохгүй юм байна даа.



Тэмүгэ: Танилцъя. Намайг Тэмүгэ гэдэг. 4-р ангид сурдаг.

Мөнх-Учрал: Намайг Мөнх-Учрал гэдэг.


Тэмүгэ: Хоёулаа хүүхдүүдтэй хамт жимсэнд явъя.

Мөнх-Учрал: Өнөөдөр чадахгүй нь ээ. Би хургаа хариулах ээлжтэй. Бид нар ээлжээр хурга, тугалаа хариулдаг юм.

Тэмүгэ: Заавал уу?

Мөнх-Учрал: Тиймээ. Үнээ, тугалаа нийлүүлбэл сүү уухгүй болно шүү дээ.

Мөнх-Учрал хотод амарсан нь



Мөнх-Учрал: Хотод очиж, мал хариулах ээлжгүй нэг сайхан, ээлжгүй амрая байз.

Ээж нь: Чи тэгж бодож байна уу? Зөвхөн хөдөө л дүрэм, журам байдаг гэж үү?

Ах нь: Чи сайн бодох л хэрэгтэй дээ. Гэхдээ тэнд ямар дүрэм байгааг очоод хар даа.


Мөнх-Учрал: Ааваа та яагаад зогсоод байнаа, хурдан яваач ээ.

Аав: Болохгүй охин минь тэр ногоон гэрлээр хүмүүс зам гарч байна.

Мөнх-Учрал: Та тэгээд хэзээ явах юм бэ?

Аав нь: Энэ улаан гэрэл унтарч, ногоон гэрэл асахаар явна.

Мөнх-Учрал: Тэгвэл ч мөдгүй юм байна даа.



Мөнх-Учрал: Хоёулаа энэ замаар гүйж гараад, тэр автобусанд гараа өргөөд сууя. Хурдлаарай.

Тэмүгэ: Болохгүй ээ, ногоон гэрлээр, гарцаар гарах ёстой. Тэгээд ч хаанаас ч хамаагүй автобусад сууж болохгүй шүү дээ. Зогсоол дээрээс сууна.

Мөнх-Учрал: Тэгвэл мөдгүй юм байнаа, би бие засмаар байна. Яах вэ?

Тэмүгэ: Хоёулаа, цэцэрлэгт хүрээлэн рүүгээ буцаад, нийтийн бие засах газарт очъё.

Асуулт:

1. Тохиолдол бүрд гарсан дүрэм болон хэн, ямар үүрэг, хариуцлага биелүүлснийг ярилцаарай. Дараах хүснэгтийг нөхөн гүйцэтгээрэй.

Асуулт	Тэмүгэ хөдөө амарсан нь	Мөнх-Учрал хотод амарсан нь
Хэн хариуцлага хүлээж байна вэ?		
Ямар хариуцлага хүлээсэн бэ?		
Хэний өмнө хариуцлага хүлээсэн бэ?		
Хариуцлагаа биелүүлэхэд нь юу тусалсан бэ? (дүрэм, хуваарь, ёс заншил)		
Хариуцлагаа биелүүлээгүй бол ямар шийтгэл хүлээх вэ?		



Дүрэм нь хүн бүрийг үүрэг, хариуцлагаа биелүүлж, сайн хүн, сайн иргэн байхад тусалдаг. Жишээ нь, та бүхэн дүрэмгүй тоглоомын тухай төсөөлөөд үзээрэй. Хөл бөмбөгийг дүрэмгүй тоглоно гээд хаалгачгүй тогловол түүний үүргийг хэн гүйцэтгэж, багийнхныхаа өмнө хариуцлага хүлээх билээ. Мөн багийн довтлогч нь үүргээ биелүүлэхгүй зөвхөн хамгаалагч болж тоглоод байвал хэн хаалганд бөмбөг оруулах билээ. Тэгэхээр хөл бөмбөгийн дүрэм бол баг ямар гишүүдтэй байх, хэн нь ямар үүрэг, хариуцлага хүлээхийг тодорхой болгож өгнө. Багийн гишүүн бүр оногдсон үүргээ сайн биелүүлж байвал тэр багийг “хариуцлагатай, сайн тоглож байна шүү” хэмээн үзэгчид, хөгжөөн дэмжигчид болон өрсөлдөгчид нь үнэлдэг. Хариуцлага гэдэг нь таны зүгээс өөрийн болон бусдын өмнө хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлж буй үйлдэл юм.

Хариуцлагатай, сахилга баттай хүүхдүүд хэлсэн үгэндээ хүрдэг, зорьсон болон даалгасан ажлыг сайн гүйцэтгэдэг, хүмүүсийн итгэлийг даадаг, нөхөдтэйгээ зөв харилцаж, хаана ч явсан биеэ зөв авч явж хэвшсэн байдаг. Үүрэг, хариуцлага хүлээж сурах нь өөрт ч хэрэгтэй, бусад хүмүүст ч хэрэгтэй. Гэхдээ үүргээ биелүүлж, хариуцлагатай байхад суралцах нь заримдаа амаргүй. Танд биелүүлэх үү?, яах вэ? гэдэг сонголт хийх ч тохиолдол гарна. Жишээ нь, тоглох уу?, гэрийн даалгавраа хийх үү?, дүүгээ харах уу?, найзуудтайгаа кино үзэх үү? гэх мэт

Хүн бүр, гэр бүл бүр, бас байгууллага бүр дүрэмтэйг та бүхэн мэднэ. Энэ нь тэд бүгд үүрэг, хариуцлага хүлээдэг гэсэн үг. Жишээ нь, танай гэр бүлийн гишүүд, сургууль, хамт олон тогтсон ёс заншил болон дүрмийн дагуу бүгд үүрэг, хариуцлага хүлээнэ.

Асуулт:

1. Дүрэм, үүрэг, хариуцлага гэсэн үгсийг тайлбарлана уу. Яагаад бүх хүмүүс болон бүх байгууллага дүрэм баримталдаг вэ?
2. Үүрэг, хариуцлага ба дүрэм нь ямар холбоотой вэ?
3. Хариуцлагатай хүүхэд (хүн) гэж ямар хүүхдийг хэлдэг вэ? Та өөрийгөө хариуцлагатай хүүхэд гэж боддог уу? Яагаад?



1. Дүрэм яагаад ялгаатай байгаа юм бол?

№	Дүрэм	Хэн шийддэг вэ?	Хэн биелүүлэх вэ?	Биелүүлэхгүй бол ямар хариуцлага хүлээх вэ?
1	IV улиралд 8-9 долоо хоног хичээллэнэ.			
2	Нэрсийн дарааллаар жижүүр хийнэ.			
3	Хичээлээс хоцорч болохгүй.			
4	21.00 цагт гэртээ ирсэн байна.			
5	Сонгуулийн насанд хүрсэн иргэн бүр сонгуульд оролцоно.			

2. Хүснэгтийг бөглөөд үүрэг, хариуцлага яагаад чухал болохыг ярилцаарай.

№	Хэрхэн хариуцлага бий болдог вэ?	Хариуцлагаа		
		Оногдох хариуцлага	Биелүүлсэн бол	Биелүүлээгүй бол
1	Амлалт: Би найздаа 3 хоног уншаад өгөхөөр амлаж, шинэ номыг нь авсан.	Амлалтаа биелүүлж, тогтоосон хугацаандаа номыг нь буцааж өгөх	<ul style="list-style-type: none"> • Найз маань надад улам итгэх болно. • Тэр надад баярлана. • Өөртөө сэтгэл ханамжтай байна. 	
2	Даалгавар: Бид багаараа хамтран танилцуулга бэлтгэх даалгавартай.	• ???		• Хангалтгүй үнэлгээ авна.
3	Ажил, үүрэг: Би өнөөдөр тугал хариулах ээлжтэй.	<ul style="list-style-type: none"> • Тугалаа бэлчээрт гаргана. • Үнээ, тугалаа нийлүүлж болохгүй. 	• ???	
4	Хууль, дүрэм: Жолооч бүр замын хөдөлгөөний дүрэм баримтална.	• ???		• ???

СЭДЭВ 3. МИНИЙ НИЙГЭМ, СОЁЛЫН ОРЧИН



Бид нийгэм,
соёлын орчинд
оршин амьдарч,
сурч, хөдөлмөрлөж
байдаг.



Бидний ярилцах зүйл:


- Бидэнд нийгэм, соёлын орчин хэрхэн нөлөөлдөг вэ?
- Хүний нийгэм, соёлын орчин яагаад өөр, өөр байдаг вэ?

Түлхүүр үг: Нийгэм, соёлын орчин, орчны ялгаа



Нийгэм, соёлын орчин, түүнд дасан зохицох талаар өмнөх төсөөлөлдөө тулгуурлан ярилцацгаая.


а. Зураглалыг ажиглаж, асуултын дагуу ярилцаарай.



1. Өөрсдийн эргэн тойронд буй нийгэм, соёлын орчны зүйлсийг нэрлэнэ үү. Яагаад эдгээр нь нийгэм, соёлын орчинд хамаарахыг тайлбарлаарай.
2. Та бүхэнд энэ орчин хэрхэн нөлөөлдөг вэ? Та бүхэн энэ орчноос юу сурдаг вэ?
3. Та бүхэн мөн орчиндоо хэрхэн нөлөөлж, зохицон амьдардаг вэ?

б. Та бүхний өмнө хоёр өөр сурагчийн зурсан “Миний амьдралын орчин” нэртэй хоёр өөр зураг байна. Дараах асуултын дагуу ажиллаарай.

1. Зурагт юу дүрсэлсэн байна вэ? Ижил болон ялгаатай зүйлсийг нэрлэнэ үү.
2. Чиний амьдарч буй орчноос ямар ялгаатай байна вэ?
3. Яагаад хүн бүрийн амьдарч буй нийгэм, соёлын орчин өөр, өөр байдаг вэ?



Ижил зүйлс

.....

.....

Ялгаатай зүйлс

.....

.....



1. Эхийг гүйцээн хүүхдүүдийн амьдралд ямар өөрчлөлт гарч болох талаар танилцуулаарай

Болороо хотын нэгэн дүүрэгт аав, ээжийнхээ хамт амьдардаг. Энэ жил тэр 6 нас хүрчээ. Сургуульд орно гэж баярлан хөөрч, аав, ээж нь ч хичээлийн бэлтгэлийг нь хийсээр 9 дүгээр сарын 1 болжээ. Ээждээ хөтлүүлээд гартаа цэцэг барин сургуульдаа орлоо.

.....

.....

Сайнаа сумын төвийн дунд сургуульд сурч, дотуур байранд амьдардаг. Зун гэртээ очиж, аав, ээждээ туслан, мал хариулна. Нэгэн зуны амралтаар гэр бүлийнхэн нь хотод шилжин ирж, Сайнаа хотын нэгэн дүүргийн дунд сургуульд суралцах болжээ.

.....

.....

2. Хүүхдүүд ээ! Зурагт чиний амьдралын 2 үйл явдлыг дүрсэлжээ гэж төсөөлье. Энэ үед чиний амьдралд ямар өөрчлөлт гарсан, юу сурсан тухайгаа бичээрэй.



Би цэцэрлэгт орлоо.

.....

.....



Би сургуульд орлоо.

.....

.....



Инжлээрэй

Бяцхан хүү Төгөлдөр дэлхийг өөрчлөхөөр шийджээ. Гэвч дэлхий асар том, харин Төгөлдөр өөрөө жижигхэн, тэгэхлээр Төгөлдөр өөрийнхөө хотыг өөрчлөхөөр шийджээ. Гэтэл хот нь маш том, харин Төгөлдөр өөрөө жижигхэн, тэгэхлээр Төгөлдөр гэр бүлээ өөрчлөхөөр шийджээ.

Гэтэл Төгөлдөрийн гэр бүл мөн л том. Ингээд Төгөлдөрийн өөрчилж чадах ганц зүйл бол өөрийгөө өөрчлөх юм гэдгийг ойлгожээ.

Асуулт:

1. Төгөлдөр яагаад өөрчлөлт хийхийг хүссэн бэ?
2. Тэр эцэст нь юу ойлгосон бэ?
3. Чи өөрийгөө хэрхэн өөрчлөхийг хүсэж байна вэ?



Нийгэм, соёлын орчин гэдэг нь та бидний оршин амьдарч, сурч, хөдөлмөрлөж буй тэр орчин юм. Хүн нийгэм, соёлын тодорхой орчин нөхцөл, хүмүүсийн зан байдал, харилцааны хэм хэмжээнд дасан зохицож амьдрах учиртай. Та нар хэдхэн жилийн өмнө сургуульд анх элсэн орж, өдөр тутмын тань амьдралд олон өөрчлөлт гарсан билээ. Тухайлбал, тогтмол цагт хичээлдээ явах, ангийн багш, шинэ хамт олонтойгоо танилцах, сургуульдаа үдийн цай уух, олон төрлийн хичээл үзэх, гэрийн даалгавраа хийх, анги, хамт олныхоо ажилд оролцох зэргийг дурдаж болно. Та сургууль, анги, хамт олны дунд амьдарч, амжилттай суралцахын тулд тэднээс олон зүйл сурсан. Та ч бас орчиндоо нөлөөлж, бусад хүмүүс бас танаас суралцсан. Жишээ нь, та сургуулийн болон ангийн сурагчийн дүрэм, журмыг баримталж сурсан. Бусад хүүхэд, багш нартайгаа зөв харилцаж хэвшсэн.

Асуулт:

1. Та нар амьдралдаа өөрчлөлт гарч байгааг яаж мэддэг вэ?
2. Орон нутагтаа ямар өөрчлөлт хийхийг хүсч байна вэ?



Гэрийн даалгавар

“Миний мөрөөдлийн хот” сэдэвт зураг зураарай.



СЭДЭВ 4. АЮУЛ, ОСЛООС ХЭРХЭН СЭРГИЛЭХ, ХАМГААЛАХ ВЭ?



Аюул, ослоос өөрийгөө болон бусдыг урьдчилан сэргийлэх, хамгаалах олон арга байдаг.



Бидний ярилцах зүйл:

- Аюул, ослоос хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?
- Өөрийгөө болон бусдыг хамгаалах аргад сурахын ач холбогдол юу вэ?

Түлхүүр үг: Аюул, осол, гал түймэр, үер ус, газар хөдлөл



Бид өөрсдөө мэдээлэлтэй байснаар болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлж, хамгаалах боломжтой. Дараах асуултын дагуу ярилцаарай.

Юу аюултай, юу осолтой вэ? Ангилж ялгаад, яагаад аюултай болохыг хэлнэ үү.



Шинжлээрэй

Балт, Гэлэг нар 2-р ээлжинд хичээллэж, орой тардаг. Тэдний сургуулиасаа гэртээ харих гудамж нь гол төлөв нарийн, гэрэл муутай байдаг. Машин замаар хөндлөн гарахад гарц, тэмдэглэгээ байдаггүй.

Асуулт:


1. Тэд гэртээ харихдаа хэрхэн аюулгүй, зөв зорчих вэ?
2. Балт, Гэлэг нар аюул, осолгүй явахын тулд юу анхаарах хэрэгтэй вэ?
3. Тэдэнд зориулсан зөвлөгөө бичээрэй.

File Edit View Insert

Save

Та нар машинаар явах дуртай юу? Тэгвэл аюул осолгүй зорчиход юуг анхаарах хэрэгтэй вэ?

- Тохирсон суудал, бүсийг зөв хэрэглэх
- Машины арын суудалд суух
- Машинаас бууж, суухдаа суудлын даруулга бүс заавал хэрэглэх
- Жолоочийн анхаарлыг сарниулахгүй байх
- Цонхоор толгойгоо гаргахгүй байх
- Зогсоолд машин тавих, буух үед насанд хүрэгчдийн зааврыг биелүүлэх





Газар хөдөлбөл өөрийгөө хэрхэн, яаж хамгаалах вэ? Зургийг ажиглаад ярилцаарай.



Асуулт:

1. Хэн юу, юу хийж байна вэ? Хэн аюулгүй газраа зөв сонгосон бэ?
2. Хэн буруу үйлдэл хийж байна вэ? Хэнд, ямар зөвлөгөө өгөх вэ?



Цаг агаарын талаар бодит мэдээлэл авах эх сурвалж нь орон нутгийн радио, телевиз, цаг уурын алба юм. Цаг уурын болон Онцгой байдлын албанаас та нарын амьдарч буй газар нутагт үерийн болон байгалийн бусад гамшиг тохиолдож болзошгүй талаар сэрэмжлүүлэх мэдээлэл өгдөг.

Малчид зун, намартаа малдаа тарга хүч авхуулах, өвс хадлан бэлтгэх, хашаа саравч, гэр орноо янзалдаг. Мөн малын өтөг бууцаа хатаах, отор нүүдэл хийх, хужир шүү, дулаан хувцас, түлээ түлшээ бэлтгэх зэрэг их ажил хийдэг. Иймээс малчид, тариаланчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ нь чухал ач холбогдолтой.



Асуулт:

1. Танай нутагт үер усны аюултай ямар газар байдаг вэ?
2. Танай орон нутгийн байгууллага, хувь хүмүүс аюул, ослоос сэргийлэх, хамгаалах талаар юу хийдэг вэ?



1. Телевиз, радио, сонин хэвлэлээр нийтэд мэдээлдэг цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг ашиглан хүснэгт нөхөж ярилцаарай.

№	Цаг агаарын үзэгдлийн нэр	Цаг уурын тэмдэглэгээ	Голчлон хэдийд болдог үзэгдэл вэ?	Хэрхэн сэргийлэх вэ?
1	Хүчтэй салхи			
2	Цасан шуурга			
3	Мөндөр			
4	Цочир хүйтрэлд			
5	Усны үер			

2. Та нарт аюул, осол болсон зургийг харуулж байна. Эдгээр аюул, осол манай улсын хаана голлож болдог вэ? Ямар хор уршиг учруулдаг вэ? Тэдгээрээс газрын зурагт тэмдэглээрэй.





Халуун орны нэгэн улсад аадар бороо их хэмжээгээр орсны улмаас голын усны түвшин нэмэгдэж, эрэг нь нуржээ. Мөн олон байшин, барилга усанд автаж, зам, гүүр эвдэрчээ. Гол мөрний усны түвшин нэмэгдсэн тул улсын ерөнхийлөгч зарим сургуулийг түр хаах шийдвэр гаргасан. Харин зарим хүмүүс сургуулийг хаах нь хүүхдүүдэд хохиролтой тул зөв шийдвэр биш гэж үзэв.

Асуулт:

1. Та бүхэн дээрх хоёр шийдвэрийн алийг нь дэмжиж байна вэ? Яагаад?
2. Байгалийн гамшиг болон бусад аюулын үед авч болох арга хэмжээнүүдээс нэрлэж, тухайн арга хэмжээ нь ямар ач холбогдолтойг тайлбарлаарай.



1. Та нар хөдөө аялал, зугаалга болон удаан хугацаагаар явахдаа эдгээрээс авч явах хамгийн чухал 2 зүйлээ сонгоорой. Яагаад сонгосноо тайлбарлаарай.



Гэрийн даалгавар:

Даалгавар	Нөхөж бичээрэй
Гал унтраах албаны утасны дугаарыг олох	
Гэрийн ойролцоох гал алдах аюултай зүйлсийг нэрлэх	
Чүдэнз болон гал асаах хэрэгслийг хаана хадгалах вэ?	
Шатамхай, гал гаргагч аюултай зүйлсийг нэрлэнэ үү.	